



Mongol Bank



МОНГОЛБАНК

ИНФЛЯЦЫН ТАЙЛАН

2022

3-Р САР

АГУУЛГА

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ	3
МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР	3
ТОЙМ.....	4
I. ИНФЛЯЦ	6
ШИГТГЭЭ 1: ИНФЛЯЦАД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС	8
Инфляцын цаашдын төлөв.....	9
II. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ	10
Нийт эрэлт	10
Нийт нийлүүлэлт.....	11
Потенциал үйлдвэрлэл	13
Үйлдвэрлэлийн зөрүү	13
Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв.....	13
III. ДОТООД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН	16
III.1. Хөдөлмөрийн зах зээл	16
III.2 Мөнгө, санхүүгийн зах зээл	19
III.2.1 Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд.....	19
III.2.2 Хүү.....	22
III.2.3 Валютын ханш.....	23
III.2.4 Хөрөнгийн зах зээл	24
III.3 Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр.....	26
ШИГТГЭЭ 2. ИРЭЭДҮЙН ӨВ САН (ИӨС)	27
IV. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН	29
IV.1 Эдийн засгийн гадаад орчны төсөөлөл.....	29
IV.2 Түүхий эдийн үнэ.....	30
IV.3 Төлбөрийн тэнцэл	32

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН СТРАТЕГИ

Төв банкны тухай хуульд **Монголбанкны үндсэн зорилт нь төгрөгийн тогтвортой байдлыг хангах** гэж тодорхойлсон байдаг. Энэ зорилтын хүрээнд Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцыг дунд хугацаанд зорилтот түвшний орчимд тогтворжуулах бодлогыг жил бүрийн “Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл”-д тусган хэрэгжүүлж байна. Инфляцыг нам түвшинд тогтворжуулснаар иргэдийн бодит орлого, хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, банк санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал хангагдах нөхцөлийг бүрдүүлэх төдийгүй хөрөнгө оруулалт, эдийн засгийн өсөлтийн тогтвортой байдлыг дэмжинэ. Монголбанк хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн **инфляцыг 2022-2024 онд жилийн 6 хувь орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулахыг** зорьж байна.

Монголбанкнаас мөнгөний бодлогын хүрээнд бодлогын хүүг өөрчилснөөр санхүүгийн зах зээлийн хүү, мөнгө, зээлийн эрэлт, нийлүүлэлтэд, улмаар үйлдвэрлэлийн хэмжээ, хөрөнгийн үнэ, хүлээлт, валютын ханш, дотоод эрэлтэд нөлөөлөх замаар инфляцын түвшин, түүний хүлээлтийг тогтворжуулахыг зорьдог. Түүнчлэн, 2018 оноос эхлэн макро зохистой бодлогын хүрээнд системийн хэмжээнд мөрдүүлэхүйц банкны зохистой харьцааны хэрэгслүүдээр дамжуулан банкны зээлийн хэт өсөлт, үүний аль нэг салбар, бүтээгдэхүүн эсвэл гадаад валютад хэт төвлөрсөн байдлыг оновчтой удирдах зэрэгт чиглэсэн арга хэмжээг бодлогын хүүтэй хослуулан хэрэглэх стратегийг баримталж байна.

Монголбанк мөнгөний бодлогын үр нөлөөг сайжруулахын тулд олон нийттэй нээлттэй харилцахад ач холбогдол өгч байна. Иймд Монголбанк макро үзүүлэлтүүдийн гүйцэтгэл, инфляц, эдийн засгийн ойрын төлөв байдал, түүнд нөлөөлж буй гадаад эдийн засаг, санхүүгийн салбар, нийт эрэлт, нийлүүлэлт, ажил эрхлэлт, үнэ ба зардлын хүчин зүйлс зэргийг Инфляцын тайланд танилцуулж, улирал тутам олон нийтийн хүртээл болгож байна. Төв банкны зорилтод нийцтэй, инфляцын төсөөлөлд үндэслэн авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын арга хэмжээ, мөнгөний бодлогын шийдвэр гаргагчдын зорилтыг олон нийтэд ийнхүү нээлттэй танилцуулснаар Монголбанкны бодлогын ил тод байдлыг хангах, Монголбанкинд итгэх итгэлийг дээшлүүлэх замаар зах зээлд оролцогчдын хүлээлтийг удирдах ач холбогдолтой.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭР

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 3-р сарын 23, 24-ний өдрийн ээлжит хурлаар Бодлогын хүүг 2.5 нэгж хувиар өсгөж 9 хувьд хүргэх шийдвэр гаргалаа. Мөнгөний бодлогын 2022 оны 3-р сарын 24-ний мэдэгдлийн дэлгэрэнгүйг [эндээс](#) уншина уу.

Инфляцын тайланд орсон тоон өгөгдөл, зураг, хүснэгтийг [дараах](#) линкээр татаж авах боломжтой.

ТОЙМ

Олон улсын харилцааны нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхий дахинд тодорхой бус байдал эрс нэмэгдэн, түүхий эдийн үнэ, тэр дундаа газрын тос, байгалийн хийн үнэ огцом өсөж, богино хугацаанд дэлхий нийтээр инфляц даамжрах, эдийн засгийн өсөлт удаашрах эрсдэлийг бий болгож байна. Манай орны хувьд ч энэхүү нөхцөл байдал нь гадаад, дотоод орчны тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, шатахуун болон бусад импортын үнийн шууд болон дам нөлөөгөөр инфляцыг эрчимжүүлэхийн зэрэгцээ үйлдвэрлэлийн зардлыг өсгөж, эдийн засгийн өсөлтийг сааруулах нөлөөтэй байна. Цаашид урд болон хойд хилийн нөхцөл байдал, түүнтэй холбогдон эдийн засгийн идэвхжил төсөөллөөс саарах, зардлын болон нийлүүлэлтийн гаралтай инфляц илүү нэмэгдэх эрсдэлтэй байна.

Олон улсын харилцаанд шинээр үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор инфляцын төсөөлөл нэмэгдлээ. Инфляц 2022 оны 2-р сард улсын хэмжээнд жилийн 14.2 хувь, Улаанбаатар хотод 15.5 хувийн өсөлттэй гарав. Үүнд, гадаад талаас олон улсын зах зээл дээрх нефтийн үнийн өсөлт, тээвэр логистикийн саатал, түүнээс улбаатай тээврийн нэмэлт зардал, нийлүүлэлтийн доголдол, гадаад инфляц зэрэг нь нөлөөлөв. Дотоод талаас тээврийн болон үйлдвэрлэлийн зардал өссөн, малын гоц халдварт өвчин дэгдсэн нь нөлөөллөө. Хилийн боомтын хязгаарлалтаас үүдэн импортын барааны үнэ төдийлөн буурахгүй байх, олон улсын харилцаанд үүсээд буй нөхцөл байдалтай уялдан дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ, хүнсний үнэ, гадаад инфляц эрчимжихээр байгаа нь 2022 оны инфляцын төсөөллийг нэмэгдүүллээ. Инфляц мөн өмнөх төсөөллөөс нэмэгдсэн хэдий ч 2023 оноос Төв банкны зорилтот интервал болох 6 ± 2 хувьд тогтворжих төсөөлөлтэй байна.

Гадаад эдийн засагт үүссэн нөхцөл байдалтай уялдуулан эдийн засгийн өсөлтийн төлөвийг өмнөх төсөөллөөс буурууллаа. Эдийн засаг 2021 онд жилийн дүнгээр 1.4 хувиар өссөн хэдий ч IV улиралд агшиж хүлээлтээс бага гарлаа. Хилийн хязгаарлалттай холбоотойгоор нүүрсний экспорт удааширсан, газрын тос, төмрийн хүдрийн экспорт сүүлийн саруудад зогссон нь уул уурхайн өсөлтийг сааруулав. Засгийн газар, төв банкнаас хэрэгжүүлж буй эдийн засгийн сэргэлтийг дэмжих бодлогын нөлөөгөөр зарим салбарын үйлдвэрлэл өссөн боловч хилийн хязгаарлалтаас шалтгаалан барилга, тээврийн үйлдвэрлэл болон бүтээгдэхүүний татвар бүрдүүлэлт төсөөллөөс муу байж, өрхийн хэрэглээ сэргээгүй хэвээр байна. Олон улсын харилцааны нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ огцом өсөж, үйлдвэрлэлийн зардлыг нэмэгдүүлэх, БНХАУ-ын Ковидын эсрэг бодлоготой холбоотойгоор үйлдвэрлэлийн орцын нийлүүлэлт хязгаарлагдаж байгаа нь 2022 оны өсөлтийн төлөв муудахад нөлөөлөхөөр байна.

Олон улсын харилцаанд үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор гадаад болон дотоод орчны тодорхой бус байдал эрс нэмэгдэв. Эдийн засгийн төсөөллийг цаашид олон улсын харилцааны нөхцөл байдал даамжрахгүй, хилийн хязгаарлалт алгуур сулрана зэрэг таамаглалын хүрээнд боловсруулсан бөгөөд эдгээр таамаглалт нөхцөл бодит байдлаас зөрөх нь цаашдын төсөөлөл өөрчлөгдөх гол хүчин зүйл болохоор байна.

Нэгдсэн төсвийн 2022 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн тэнцэл 32 тэрбум төгрөгийн эерэг дүнтэй гарлаа. Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2.5 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 52 хувиар буюу 841 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд үүний дийлэнх хэсэг нь өмнөх жилүүдэд Ирээдүй өв санд бүртгэдэг байсан ашигт малтмалын нөөц

ашигласны төлбөрийг тэнцвэржүүлсэн орлогод бүртгэсэн, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлтийн суурь нөлөө үргэлжилж байгаатай холбоотой байна. Харин төсвийн нийт зардал энэ оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 40.0 хувиар буюу 696 тэрбум төгрөгөөр өсөж 2.4 их наяд төгрөгт хүрэв.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарч, банкуудын зээлийн өсөлт алгуур нэмэгдсэн хэвээр байна. Тодруулбал, сүүлийн саруудад гадаад валютын цэвэр урсгал сөрөг байгаа нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарахад голлон нөлөөлөв. Өмнөх оны эхний 3 улиралд “Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний нөлөөгөөр банкны системийн зээлийн өсөлт эрчимжиж байсан бол оны сүүлийн саруудад иргэдийн хэрэглээ болон хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт нэмэгдэж эхэлсэн нь нийт зээлийн өсөлтөд нөлөө үзүүлээ.

Гадаад эдийн засгийн төлөв муудаж, гадаад тодорхой бус байдал эрс нэмэгдлээ. Дэлхий дахинд эдийн засгийн төлөв муудахад олон улсын харилцаанд үүссэн хурцадмал байдлыг дагасан эдийн засаг, санхүүгийн хориг арга хэмжээ, энергийн болон хүнсний үнийн өндөр өсөлт, нийлүүлэлтийн сүлжээний доголдол, түүнчлэн цар тахлын нөхцөл байдал, БНХАУ-ын өсөлт удаашрах төлөв, хүлээлтээс давсан инфляц, мөнгөний бодлого чангарах нь нөлөөлж байна. Түүнчлэн, олон улсын харилцаанд үүссэн нөхцөл байдал нь гадаад орчны тодорхой бус байдлыг эрс нэмэгдүүлж байна.

Төмрийн хүдрээс бусад түүхий эдийн үнийн төлөв өмнөхөөс сайжирсан ч импортын үнэ өссөнөөр худалдааны нөхцөл муудахаар байна. Эрэлт өндөр, нийлүүлэлт хязгаарлагдмал байгаагаас газрын тос, зэс, нүүрсний үнэ өмнөх төсөөллөөс өслөө. Ялангуяа, олон улсын харилцаанд үүссэн нөхцөл байдлаас үүдэн газрын тос, байгалийн хийн нийлүүлэлт буурч, үнэ огцом өсөөд байгаа бөгөөд цаашдын түүхий эдийн үнийн төлөв үүсээд буй нөхцөл байдлаас хүчтэй хамаарахаар байна. Түүнчлэн, олон улсын харилцаанд үүссэн хүндрэлээс улбаалан 2022 онд газрын тос, хүнсний үнэ өндөр түвшинд хадгалагдах хүлээлттэй байгаа нь импортын үнийг экспортын үнээс хурдтай өсгөж, худалдааны нөхцөл өмнөх төсөөллөөс муудахад нөлөөлөв. Харин БНХАУ-ын үл хөдлөх салбарын хямралаас шалтгаалж төмрийн хүдрийн үнийн төлөв хүлээлтээс муудав.

Төлбөрийн тэнцлийн 2021 оны 4 дүгээр улирлын гүйцэтгэлийг авч үзвэл 358.6 сая ам.долларын ашигтай гарлаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тайлант улиралд урсгал дансны алдагдал тэлж, хөрөнгө, санхүүгийн дансны ашиг буурснаар төлбөрийн тэнцлийн ашиг цэвэр дүнгээр буурчээ. Мөн 2021 оны туршид импорт экспортоос хурдтай тэлж, гадаад худалдааны ашиг буурсан, аж ахуйн нэгжүүдийн дахин хөрөнгө оруулалт нэмэгдэж, орлогын дансны алдагдал тэлснээр урсгал тэнцлийн алдагдал өмнөх оноос 2.9 дахин тэлж, Дотоодын нийт бүтээгдэхүүний 13 хувьд хүрсэн байна.

I. ИНФЛЯЦ

Монголбанк хэрэглээний үнийн индексээр хэмжигдсэн инфляцыг 2022-2024 онд жилийн б хувийн орчимд, +/-2 нэгж хувийн интервалд тогтворжуулах зорилттойгоор ажиллаж байна.

Инфляц өмнөх улирлаас нэмэгдэхэд нэг талаас эдийн засгийн аажим сэргэлт тодорхой хэмжээнд нөлөөлж байгаа бол дийлэнх хэсгийг нь нийлүүлэлтийн хүчин зүйлс тайлбарлаж байна. Инфляц¹ 2021 оны IV улиралд улсын хэмжээнд 11.2 хувь, Улаанбаатар хотод 11.4 хувь болж III улирлаас харгалзан 2.6 болон 2.4 нэгж хувиар нэмэгдэв (Зураг I.1). Үүнд, шатахууны үнэ 2021 онд жилийн 48.3 хувиар өссөн байна. Түүнчлэн, махны нийлүүлэлт буурсан, хилийн хязгаарлалт үүсэж, гадаад худалдааны тээвэр, логистикийн зардал эрчтэй нэмэгдсэн зэрэг нь том нөлөөтэй байв (Зураг I.2).

Зураг I.1

Инфляц



Эх сурвалж: УСХ

Энэ оны эхний саруудад хилийн боомтын нөхцөл байдал сайжрахгүй байгаагийн дээр төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ өссөнөөр 2 дугаар сард инфляц улсын хэмжээнд жилийн 14.2 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 15.5 хувьд хүрлээ (Зураг I.1, I.2, I.3).

Зураг I.2

Ерөнхий инфляц болон инфляцад өндөр нөлөөтэй бүтээгдэхүүнүүдийн жилийн өсөлт



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Энэ оны 2 дугаар сарын инфляцын хөдөлгөөнд гол нөлөөлж буй бүтээгдэхүүнүүд:

Махнаас бусад дотоодын хүнсний хувьд 2021 оны 10 дугаар сараас эхлэн үнэ эрчтэй нэмэгдэж инфляцын 2-оос дээш нэгж хувийг бүрдүүлж байна. Дотоодын хүнсний үнэ нэмэгдэхэд нэг талаас үйлдвэрлэл, тээврийн зардал өссөн, нөгөө талаас “Шинэ жил”, “Цагаан сар” зэрэг баярын үе давхацсан байна.

Дотоодын махны үнийн хувьд үнэ улирлын хандлагаараа өсөж, инфляцад үзүүлэх нөлөө нь 1.5 нэгж хувь байна (Зураг I.2, I.3).

Гадаад худалдааны тээвэр логистикийн асуудлууд шийдэгдээгүйн дээр худалдааны түнш орнуудын үнийн өсөлт эрчимжсэн нь импортоор дамжин инфляцыг нэмэгдүүлэх нөлөө үзүүлж байна. Үндэсний Статистикийн Хорооны хорооны мэдээллээс харахад нийт инфляцын 50 орчим хувь нь импортын инфляц байна. Тухайлбал, **импортын бараа**² инфляцын 3.0 нэгж хувийг, импортын хүнс 1.9 нэгж хувийг бүрдүүлэв. Тайлант хугацаанд төгрөгийн ханш тогтвортой байсан хэдий ч улс хоорондын ачаа тээврийн эргэлт сайжраагүй, түүнээс шалтгаалсан тээвэр логистикийн өндөр зардал хадгалагдсан, худалдааны түнш


¹ Улирлын дундаж инфляц

² Хүнсний бус импортоос шатахууныг хассан бүлэг

орнуудад үнийн өсөлт эрчимжсэн зэрэг нь импортын үнэ хурдтай нэмэгдэх үндэслэл болж байна (Зураг I.2, I.3).

Зураг I.3

Улаанбаатар хотын жилийн инфляцын бүрэлдэхүүнээр



Эх сурвалж: ҮСХ, Монголбанк

Дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ³ хурдтай өсөж буй нь хилийн үнээр дамжин дотоодын шатахууны үнэ өндөр түвшинд хадгалагдах үндэс болж байна. Шатахууны үнэ өмнөх онд дунджаар 840 төгрөгөөр, 2022 он гарснаар дунджаар 130 төгрөгөөр өсөж инфляцын 2.2 нэгж хувийг бүрдүүлэв (Зураг I.2, I.3).

Төрийн зохицуулалттай бараа, үйлчилгээний инфляцад үзүүлэх нөлөө 2021 оны 12 дугаар сараас эхлэн нэмэгдэв. Засгийн газрын шийдвэрээр сайжруулсан түлш 50 хувийн хөнгөлөлттэй үнээр худалдаалагдаж байгаа ч хөнгөлөлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 25 нэгж хувиар бага учир суурь нөлөөгөөр инфляцыг 0.7 нэгж хувиар нэмэгдүүлж байна (Зураг I.2, I.3). Мөн усны тариф гэр хороололд 100 хувь, орон сууцанд 50 хувиар нэмэгдсэнээр төрийн зохицуулалттай үйлчилгээний инфляцад үзүүлэх нөлөө 0.4 нэгж хувиар нэмэгдэн 0.6 нэгж хувийг бүрдүүлж байна (Зураг I.3).

Төсөөллийн зөрүү

2021 оны IV улирлын дундаж инфляц 11.4 хувь гарсан нь өмнөх улирлын төсөөллөөс 0.8 нэгж хувиар өндөр байв. Тодруулбал, хилийн хязгаарлалтаас үүдэлтэй тээврийн саатал, нийлүүлэлтийн доголдлын бараа бүтээгдэхүүнд үзүүлэх нөлөө төсөөллөөс өндөр байж хүнсний бус инфляц жилийн 8 хувь өссөн бол махны нийлүүлэлт, хилийн хязгаарлалт нь хүнсний үнэд нөлөөлөн хүнсний инфляц жилийн 20 хувиар нэмэгдсэн нь төсөөллөөс их байв.

Хүснэгт I.1 Инфляцын төлөвт гарсан өөрчлөлт

Инфляцын богино хугацааны суурь төсөөллийн таамаглал	
Өмнөх төсөөлөл 2021Q4-2022Q3	Одоогийн төсөөлөл 2022Q1-2022Q4
Мах	Төсөөлөл нэмэгдсэн
Махны үнэ 10-р сард өндөр байсан, мөн аймгуудад малын гоц халдварт өвчин дэгдсэнгэй холбоотойгоор цаашдын төсөөллийг нэмэгдүүллээ.	Махны үнэ төсөөллөөс багаар буурсан учир цаашдын төсөөллийг нэмэгдүүлэв. Цаашид махны нийлүүлэлт тогтвортой байх таамаглалд үндэслэн төсөөллийг боловруулав.
Махнаас бусад хүнс	Төсөөлөл нэмэгдсэн
Хилийн хязгаарлалтын сөрөг нөлөөгөөр импортын хүнс, дотоодын хүнсний ногооны үнэ эрчтэй өссөн, мөн уг хязгаарлалт импортын хүнсний үнэд нөлөөлөх учир төсөөллийг нэмэгдүүлэв.	Хилийн хязгаарлалтын хүнсний үнэд үзүүлэх сөрөг нөлөө төсөөллөөс өндөр байв. Түүнчлэн тээвэр, логистикийн нөхцөл байдал сайжрахгүй байгаагаас цаашдын төсөөллийг нэмэгдүүлэв.
Импортын бараа	Төсөөлөл нэмэгдсэн
Төгрөгийн ханш тогтвортой хэдий ч тээвэр логистик, гадаад үнэ өссөн нөлөөгөөр импортын барааны үнэ өснө. Үнийн өсөлт өмнөх төсөөллийн орчимд байна.	Төгрөгийн ханш суларсан, тээвэр логистикийн асуудал сайжрахгүй, гадаад инфляцын төсөөлөл нэмэгдсэн зэрэг нөлөөгөөр импортын барааны үнийн төсөөллийг нэмэгдүүлэв.
Дотоодын бараа	Төсөөлөл буурсан
Сайжруулсан түлшний үнэ 1-р улирал дуустал 50 хувийн хөнгөлөлттэй байх	Сайжруулсан түлшний үнэ 2022 оны туршид 50 хувийн хөнгөлөлттэй байх
Төрийн зохицуулалттай үйлчилгээ	Төсөөлөл нэмэгдсэн
Хот хоорондын зорчигч тээврийн үнэ өссөн бол цаашид төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэ хэвээр байна.	Усны тариф 1-р сард өссөн бол цаашид төрийн зохицуулалттай үйлчилгээний үнэд өөрчлөлт орохгүй.
Шатахуун	Төсөөлөл нэмэгдсэн
Хилийн үнэ болон олон улсад газрын тосны үнэ өндөр байгаагаас шатахууны үнэ өсөх гадаад эрсдэл өндөр хэвээр байна. Цаашдын төсөөлөл 11-р сарын үнийн өсөлттэй уялдан нэмэгдэв.	Олон улсад газрын тосны үнэ эрс өссөн учир шатахууны үнэ өсөх гадаад эрсдэл нэмэгдэж байна. Үүнтэй уялдаад шатахууны үнэ 1-3-р саруудад өссөн бөгөөд цаашдын төсөөллийг мөн нэмэгдүүлэв.

Эх сурвалж: Монголбанк

³ Brent газрын тосны үнэ 3 дугаар сарын 21-ий байдлаар \$111/баррель

ШИГТГЭЭ 1: ИНФЛЯЦАД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛС

“КОВИД-19” цар тахлаас шалтгаалан агшсан глобал эдийн засаг 2021 онд хурдтай сэргэж нийлүүлэлтээс давсан эрэлтийг үүсгэсэн нь дэлхий нийтээр инфляцыг эрчимжүүллээ. Үүний дээр олон улсад тээвэр логистикийн саатал бий болсноор тээврийн зардал өсөх, нийлүүлэлт тасалдах зэргээр зардлын шалтгаантайгаар инфляц нэмэгдэх нөлөөг үзүүлж байна. Тодруулбал, олон улсын тээвэр, логистикийн төлөв сайжрахгүй байгаагийн зэрэгцээ тээврийн зардал 2020 оноос 3-4 дахин өндөр хэвээр байна (Зураг Ш.1). Үүнд:

- Төлөвлөсөн далайн тээвэр цуцлагдах эсвэл хойшилсноос шалтгаалж далайн боомтуудад чингэлгийн бөөгнөрөл үүссэн;
- Дээрх асуудлаас улбаалаад нэг талдаа чингэлэг хомсдож, ачаа тээврийн эргэлт удааширсан нь нөлөөлж байна.

Мөн БНХАУ “Тэг-Ковид” бодлогын улмаас өнгөрсөн оны сүүлээс хилийн хязгаарлалтаа чангатгасан нь манай улсын ачаа тээврийн эргэлтэд сэргөөр нөлөөлж нийлүүлэлт доголдох, удааших зэргээр дотоодын үнэ өсөх нөхцөлийг үүсгэв.

Зураг Ш.1: Импорт, дотоодын барааны инфляц болон үйлдвэрлэгчийн үнийн индекс




Эх сурвалж: YCХ, Монголбанк, Dallas Fed Global Economic Conditions Database

Цаашид ОХУ-Украины хурцадмал байдлаас шалтгаалан тээврийн ачаалал нэмэгдэж болзошгүй байгаа нь тээвэр логистикт үүссэн хүндрэл даамжрах бодит эрсдэлийг бий болголоо.

Түүнчлэн, геополитикийн асуудлаас үүдэн дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ, үйлдвэрлэлийн зардал өсөж байна (Зураг 1). Тухайлбал, Brent газрын тосны үнэ 2021 оны эхэнд баррель нь 56\$ байсан бол 2022 оны 1-р сард 91\$-т хүрч жилийн дотор даруй 63%-иар өссөн (Зураг Ш.2). Энэ оны 2-р сарын дундаас эхлэн дэлхийн газрын тосны экспортын 11%-г, Европын 30%-ийг нийлүүлдэг ОХУ-Украины хооронд геополитикийн хүндрэл үүссэн нь газрын тосны үнийг улам хөөрөгдлөө. Brent газрын тосны үнэ 3-р сарын 23-ны байдлаар баррель нь 122\$-т хүрсэн нь 1-р сарын дундаж үнээс 33%-иар өссөн дүн юм (Зураг Ш.2). Энэ нь дотоодын шатахууны үнэ дахин өсөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Зураг Ш.2: Газрын тос, тээврийн үнэ



Эх сурвалж: Bloomberg, FBX Container Index


Ирэх саруудад ОХУ-Украины байдлаас хамааран олон улсын зах зээл дээрх хүнс, ялангуяа улаанбуудай, ургамлын тос мөн, түүхий эдийн үнийн өсөлт дахин эрчимжих хандлага бий болоод байна.

Инфляцын цаашдын төлөв

Өмнөх төсөөлөлтэй харьцуулахад инфляцын төсөөлөл нэмэгдлээ. Олон улсын харилцаанд шинээр үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор тодорхой бус байдал ихээхэн нэмэгдээд байгаа бөгөөд дэлхийн зах зээл дэх газрын тос болоод ХАА-н түүхий эдийн үнийн өсөлт эрчимжиж, гадаад инфляц нэмэгдэх эрсдэл бий болсон нь инфляцын төсөөллийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл болж байна.

Зураг I.4

Инфляцын төсөөлөл



Эх сурвалж: Монголбанк

Мөн БНХАУ-ын хилийн боомтын хязгаарлалттай холбоотой нийлүүлэлтийн саатал үргэлжилж, импортын барааны үнэ өндөр түвшинд хадгалагдаж, цэвэр, бохир усны тариф оны эхнээс нэмэгдсэн зэрэг нь инфляцын төсөөллийг өмнөхөөс нэмэгдүүлэхэд нөлөөллөө (Зураг I.4). Цаашид ОХУ-Украины нөхцөл байдлаас үүдэлтэй тодорхой бус байдал, нийлүүлэлтийн хязгаарлалтаас шалтгаалж зардлын инфляц бий болох, инфляцын хүлээлт өсөхөөр байгааг харгалзан мөнгөний бодлогын төлөвийг чангаруулж бодлогын хүүг нэмэгдүүлсэн⁴ нь инфляцын дараа үеийн нөлөө болон хүлээлтийг тогтворжуулах нөлөө үзүүлнэ гэж үзэж байна.

Инфляц 2022 онд өсөж зорилтот түвшнээс өндөр байх хэдий ч ирэх оноос зорилтот түвшний дээд хязгаарт хүрч, цаашид

⁴ МБХ-ны 2022 оны 3-р сарын ээлжит хурлаар мөнгөний бодлогын хүүг 9 хувьд хүргэж нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн.

Инфляцын тайлан 2022 оны 3 дугаар сар

тогтворжих төлөвтэй. Энэ онд олон улсын харилцааны нөхцөл байдлаас шалтгаалж дэлхийн зах зээл дэх газрын тосны үнийн түвшин огцом өсөж, төсөөлөл нэмэгдээд байгаа нь дотоодын шатахууны үнийг нэмэгдүүлж, түүний дам нөлөөгөөр бусад бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт нэмэгдэхээр байна. Хилийн боомтын хязгаарлалт энэ онд үргэлжлэх, үүн дээр нэмэгдэн ОХУ-Украины нөхцөл байдлаас шалтгаалж бүс нутгаар дамжих ачаа тээвэр саатах эрсдэл өндөр болж, тээврийн үнэ өсөхөөр байгаа нь тээвэр, логистикт гарах хүндрэлийг даамжруулж, импортын барааны инфляцад үзүүлэх нөлөө нэмэгдэх, үйлдвэрлэлийн зардал өсөж дотоодын бараа бүтээгдэхүүний үнэ өсөхөд нөлөөлж байна. Ийнхүү нийлүүлэлтийн шинжтэй инфляц эрчимжсэн хандлага ирэх улирлуудад хадгалагдаж, инфляцыг хүлээлтээс илүү нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

Хүснэгт I.2

Инфляцын төсөөлөл

	2021	2022*	2023*	2024*
		<i>төсөөлөл</i>		
Инфляц ⁵	11.4	12.3 [8.3-16.5] ⁶	6.5 [3.1-10.0]	7.0 [4.5-9.6]

Эх сурвалж: Монголбанк

Дотоод эдийн засгийн өсөлтийн төлөв саарснаар эрэлтийн шинжтэй инфляц эрчимжих хугацаа хойшилсон ч дунд хугацаанд алгуур нэмэгдэх төлөвтэй. Мөн дэлхийн зах зээл дэх хүнс, газрын тос болон бусад түүхий эдийн үнэ дунд хугацаанд өндөрт хадгалагдах, олон улсын нийлүүлэлтийн сүлжээний доголдоос шалтгаалан гадаад инфляц өсөх, ханш сулрах төлөвтэй байгаа зэрэг нь гадаад талаас инфляцын дарамтыг нэмэгдүүлж байгаа ч инфляц дунд хугацаанд Төв банкны зорилтот интервалд тогтворжих хүлээлттэй байна.

⁵ ХҮИ-ээр хэмжигдэх инфляц, 4 дүгээр улирлын дундаж

⁶ 60 хувийн магадлалтай итгэх интервал

Инфляцын төсөөллийг өөрчилж болзошгүй тодорхой бус байдал

Эрсдэл, тодорхой бус байдал	Магадлал	Нөлөө
Бараа бүтээгдэхүүн, түүхий эдийн нийлүүлэлтийн доголдын нөхцөл байдал төсөөлөлд авч үзсэнээс өөрчлөгдөх, төрийн зохицуулалттай бараа үйлчилгээний үнэ өөрчлөгдөх зэрэг нь инфляцын төсөөллийг өөрчлөх шалтгаан болно.	Дунд	Өндөр (өсгөх)
ОХУ-Украины нөхцөл байдлаас шалтгаалж манай улсын хойд хилээр орж ирэх импорт тасалдах эрсдэлтэй. Түүнчлэн БНХАУ-ын “Тэг-КОВИД” бодлогын хүрээнд хилийн боомтын хязгаарлалт төсөөллөөс удаан үргэлжлэх эрсдэл өндөр хэвээр байна. Эдгээр нөхцөл байдлаас шалтгаалж бараа бүтээгдэхүүний хомсдол бий болж, инфляцыг илүү ихээр нэмэгдүүлж болзошгүй.	Өндөр	Өндөр (өсгөх)
Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ төсөөллөөс ихээр өсөх, өндөр түвшинд удаан хадгалагдах нь дотоодын шатахууны үнийг өсгөн, улмаар бусад бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг нэмэгдүүлэх, инфляцын хүлээлтийг эрчимжүүлэх эрсдэлтэй.	Өндөр	Өндөр (өсгөх)
Дэлхий нийтийн тээвэр, логистикийн түгжрэл, манай орны хилийн бүс дэх хязгаарлалт, түүний тодорхой бус байдал нь гадаад худалдааны тээвэрлэлтийн хугацаа удаашрах, тээврийн зардал өсөх, улмаар импортын болон дотоодын бараа бүтээгдэхүүний үнэ өсөх эрсдэлийг бий болгож байна.	Өндөр	Өндөр (өсгөх)
Цар тахлын тархалт дэлхийн улс орнуудад эрчимжих, вирусын шинэ хувилбарууд тархах, геополитикийн асуудал зэргээс үүдэн гадаад орчинд тодорхой бус байдал нэмэгдэх тохиолдолд дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ, манай улсыг чиглэх хөрөнгийн урсгалд сөргөөр нөлөөлж, улмаар төгрөгийн ханшид дарамт учруулж инфляцын хэлбэлзэл бий болгох эрсдэлтэй.	Бага-Дунд	Дунд (өсгөх)
Засгийн газар, Монголбанкнаас эдийн засгийг сэргээх бодлогын арга хэмжээний хүрээнд санхүүжилт олгох, Засгийн газраас томоохон төслүүд хэрэгжүүлэх зэрэг нь инфляцын төсөөллийг өөрчлөх боломжтой.	Бага	Дунд (өсгөх)
Хилийн хязгаарлалт төсөөллөөс удаан үргэлжлэх нь гадаад валютын орох цэвэр урсгалыг бууруулж, төгрөгийн ханш сулрах дарамтыг хүлээлтээс илүү нэмэгдүүлэх нь инфляцын төсөөллийг өсгөж болзошгүй.	Өндөр	Өндөр (өсгөх)

Инфляцын тайлан 2022 оны 3 дугаар сар

II. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ


Эдийн засгийн өсөлт⁷ сүүлийн гурван улирал дараалан саарсан хэдий ч бодит ДНБ жилийн дүнгээр 1.4 хувиар тэлэв. Үүний дийлэнх хэсгийг I улирлын огцом өсөлт бүрдүүлсэн бол IV улиралд эдийн засаг 3.8 хувиар агшсан байна. Түүнчлэн, ДНБ 2019 онтой харьцуулахад 2021 онд 3.2 хувиар бага байгаа нь эдийн засаг цар тахлын өмнөх түвшинд хүрч сэргээгүй байгааг илтгэж байна.

Нийт эрэлт

Нийт эрэлт⁸ 2021 онд 1.4 хувиар өсөхөд нийт хөрөнгийн хуримтлал голлон тэтгэсэн бол цар тахлаас сэргийлэх хязгаарлалтын арга хэмжээ, гадаад худалдааны тээвэр, логистикийн хүндрэл нь эцсийн хэрэглээ, цэвэр экспортод хүчтэй сөрөг нөлөө үзүүлэв (Зураг II.1).

Зураг II.1

Нийт эрэлт 4-р улиралд 3.5 хувиар агшив.



Эх сурвалж: УСХ


Дотоодод хөл хорио 2021 онд шат дараатай суларсан, засгийн газар, төв банкнаас эдийн засгийг дэмжих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн, өмнөх оны суурь үеийн нөлөө зэргээс шалтгаалан нийт хөрөнгийн хуримтлал жилийн турш хурдтай өслөө. Тухайлбал, шинээр олгосон бизнесийн зээл жилийн 43 хувь, ГШХО 5.1 хувиар өссөн бол төсвийн хөрөнгийн зардал өмнөх оны түвшинд хадгалагдсан байна (Зураг II.2).

⁷ Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ

⁸ Эцсийн ашиглалтын аргаар тооцсон ДНБ

Зураг II.2

Нийт хөрөнгийн хуримтлал өндөр өсөлттэй байв.



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Харин хилийн боомт дээрх уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт удааширснаар экспорт оны сүүлийн 3 улиралд бодит дүнгээр 20-40 хувь агшив. Харин импортын ачаа тээврийн эргэлт нэмэгдэж импорт бодит дүнгээр 2021 онд улиралд 9.6 хувиар өслөө (Зураг II.3).

Зураг II.3

Алт болон нүүрсний экспорт огцом буурав.



Эх сурвалж: УСХ


Энэ оны II улирлаас эхлэн хөл хорионы дэглэм шат дараатай суларч, иргэдийн хөдөлгөөнт байдал нэмэгдэхийн зэрэгцээ өрхийн орлогыг дэмжих зорилготой хөнгөлөлтийн арга хэмжээнүүд хэвээр үргэлжилж, макро үзүүлэлтүүдэд эерэг хандлага ажиглагдсан хэдий ч өрхийн хэрэглээ хүлээлтэд хүрч сэргэсэнгүй (Зураг II.4). Тодруулбал, IV улиралд өрхийн

Инфляцын тайлан 2022 оны 3 дугаар сар

хэрэглээ өнгөрсөн оны бага сууриас дахин 0.7 хувиар агшсан нь бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс гадна өрхүүдийн хэрэглэх хандлага сул, тээвэр логистик сааталтай хэвээр байгааг илэрхийлж байна.

Зураг II.4

Өрхийн хэрэглээ хүлээлтээс удаан сэргэж байна




Эх сурвалж: УСХ, Монголбанк

Нийт нийлүүлэлт

Эдийн засгийн өсөлтийг нийлүүлэлт⁹ талаас авч үзвэл 2021 оны нийт дүнгээр уул уурхай 1.7 хувь, уул уурхайн бус салбарууд 1.4 хувиар тус тус өсжээ. Мөн цар тахлын өмнөх үе буюу 2019 онтой харьцуулахад уул уурхай салбар 8.3 хувь, уул уурхайн бус салбарууд 2.3 хувиар тус тус бага байна (Зураг II.5).

Зураг II.5

Нийт нийлүүлэлт цар тахлын өмнөх түвшинд хүрэх болоогүй байна.



Эх сурвалж: УСХ, Монголбанк


Нийт нийлүүлэлт IV улиралд 3.8 хувиар буурахад уул уурхай, тээвэр, барилга, боловсруулах, хөдөө аж ахуйн салбаруудын

⁹ Үйлдвэрлэлийн аргаар тооцсон ДНБ

уналт нийтдээ 8.4 нэгж хувийн сөрөг нөлөөг үзүүлсэн бол худалдаа, үйлчилгээ, эрчим хүч, мэдээлэл холбооны салбаруудын өсөлт нийтдээ 4.6 нэгж хувиар тэтгэжээ (Зураг II.6).

Зураг II.6

Эдийн засгийн өсөлт салбаруудад тэгш бус, эмзэг хэвээр байна.




Эх сурвалж: YCX

Уул уурхайн олборлолт тайлант улиралд буурснаар нийт нийлүүлэлтэд 2.7 нэгж хувийн сөрөг нөлөө үзүүлжээ. Тодруулбал, нүүрс олборлолт өмнөх оны IV улиралтай харьцуулахад 62.2 хувь, газрын тос 57.3 хувь, төмрийн хүдэр баяжмал 14.4 хувь, алт олборлолт 7.0 хувиар тус тус буураад байна. Мөн Оюу толгойн ил уурхайгаас олборлож буй зэсийн баяжмал 3.9 хувь, үүнд агуулагдах цэвэр зэс 6.6 хувь, алт 18.5 хувиар тус тус багасжээ (Зураг II.7).

Уул уурхайн үйлдвэрлэлийн идэвхжил саарч байгаатай уялдан тээврийн салбар агшиж, нийт нийлүүлэлтийг 1.9 нэгж хувиар бууруулав. Тус салбар 2020 оны сүүлч, 2021 оны эхэн үеийг эс тооцвол сүүлийн 2 жил уналттай байв. Тайлант улиралд авто замын ачаа эргэлт өмнөх оны мөн үеэс 81.1 хувь, зорчигч эргэлт 18.0 хувь, төмөр замын ачаа эргэлт 17.2 хувь, зорчигч эргэлт 15.1 хувиар тус тус буурлаа.

Зураг II.7

Уул уурхайн салбарын идэвхжил эргэн саарлаа.



Эх сурвалж: YCX, Монголбанк

Барилгын салбарын хувьд сүүлийн 7 улирал дараалан агшиж байгаа бөгөөд тайлант улиралд нийт нийлүүлэлтийг 1.9 нэгж хувиар буурууллаа. Үүнд орон сууцны бус барилга угсралтын ажил бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 35.9 хувь, инженерийн барилга байгууламж 14.5 хувиар тус тус агшсан нь нөлөөлсөн бол орон сууцны барилгын ажил өөрчлөлтгүй байв.

Боловсруулах салбар эдийн засгийн өсөлтийг 0.9 нэгж хувиар сааруулах нөлөө үзүүлжээ. Үүнд дотоодод үйлдвэрлэж буй мах, үр тарианы гурил, эмийн үйлдвэрлэл болон хүнсний хэрэглээнд зориулан бэлтгэсэн мах өмнөх оны мөн үеэс буурсан нь голлон нөлөөлөв. Харин дотоодын нэхмэл, барилгын материал, төмөр, резинэн бүтээгдэхүүн болон сүү, ундааны үйлдвэрлэл тайлант улиралд нэмэгдсэн байна.

Хөдөө аж ахуйн салбар оны туршид уналттай байж, тайлант улиралд нийт нийлүүлэлтийг 0.9 нэгж хувиар бууруулав. Үүнд хүн амын хүнсний болон экспортын хэрэгцээнд зориулан бэлтгэсэн мал өмнөх оноос 7 гаруй сая толгойгоор (30.6 хувиар) бага байсан төдийгүй том малын зүй бус хорогдол 1 гаруй сая толгойгоор (45.9 хувиар) өндөр байсан нь голлон нөлөөлөв.

Өргөн хэрэглээний түргэн болон удаан эдэлгээт барааны импорт эрчимжсэнээр дотоод худалдааны салбар өсөж, нийт

нийлүүлэлтийг 1.4 нэгж хувиар тэтгэв. Харин машин механизм, тоног төхөөрөмж, барилгын материалын худалдаа тайлант улиралд төдийлөн өндөр өсөөгүй байна.


Ажиллах хүч ихээр шингээдэг үйлчилгээний салбар тайлант улиралд нийт нийлүүлэлтийг 2.7 нэгж хувиар дэмжлээ. Уг өсөлтийг санхүү даатгалын зуучлал, эрүүл мэндийн үйлчилгээ, үл хөдлөх хөрөнгийн зуучлал, төрийн удирдлагын үйл ажиллагаа, зочлох үйлчилгээний салбарууд голлон бүрдүүлсэн байна.

Потенциал үйлдвэрлэл

Уул уурхайн салбарт хийгдсэн бүтээн байгуулалтын нөлөөгөөр уул уурхайн бус салбар идэвхжиж, 2017-2019 онд потенциал үйлдвэрлэлийн өсөлт нэмэгдсэн бол КОВИД-19 цар тахлын нөлөөгөөр 2020 оноос дотоод эдийн засгийн идэвхжил хумигдаж, потенциал үйлдвэрлэл буураад байгаа бөгөөд сүүлийн улирлуудад бага түвшинд хэлбэлзэж байна (Зураг II.7).

Зураг II.7

Потенциал үйлдвэрлэлийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн мэдээлэл, тэдгээрийн хоорондын хамаарлыг ашигладаг олон хувьсагчийн Калман филтерээр тооцсон потенциал үйлдвэрлэл алгуур буурч 2020 оноос хойш 1.3-3.4 хувийн хооронд хэлбэлзэж байна. Нэг хувьсагчийн НР филтерээр тооцсон потенциал үйлдвэрлэлийн

Инфляцын тайлан 2022 оны 3 дугаар сар


хувьд 2020 оны турш буурсан бол 2021 он гарсаар алгуур сэргэн тайлант улиралд 1.1 хувьд хүрээд байна. Харин үйлдвэрлэлийн функцээр тооцоход потенциал өсөлт хөдөлмөр эрхлэлтийн түвшин саарснаас үүдэн буурсан ч тайланд улиралд сэргэх хандлагатай боллоо.

Үйлдвэрлэлийн зөрүү

КОВИД-19 цар тахлаас шалтгаалсан эдийн засгийн хүндрэлээс шалтгаалан үйлдвэрлэлийн зөрүү, ялангуяа уул уурхайн бус үйлдвэрлэлийн зөрүү 2020 оноос хойш тасралтгүй сөрөг түвшинд хадгалагдаж байна. Уул уурхайн салбарын хувьд эрдэс бүтээгдэхүүний олборлолт 2020 оны сүүлийн хагасаас 2021 оны 1 дүгээр улирал хүртэл сайжирсан нь уул уурхайн үйлдвэрлэлийн зөрүүг эерэг түвшинд хүргэсэн ч сүүлийн 3 улирал хилийн хязгаарлалтаас үүдэн нүүрсний экспорт буурсан нь буцаад сөрөг болоход нөлөөллөө.

Зураг II.8

Үйлдвэрлэлийн зөрүү¹⁰



Эх сурвалж: Монголбанк

Эдийн засгийн өсөлтийн цаашдын төлөв

Эдийн засгийн өсөлт 2022 онд өмнөх төсөөллөөс саарахаар байна. Уул уурхайн бус салбарыг авч үзвэл, ОХУ-Украины нөхцөл байдалтай холбоотойгоор дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ огцом өсөж байгаа нь дотоодын үйлдвэрлэлийн зардлыг

10


GAP загварын үр дүн

нэмэгдүүлэх, мөн хилийн боомтууд дээр үүсээд буй нөхцөл байдлаас шалтгаалан ачаа тээврийн саатал, түүхий эд материалын доголдол харьцангуй удаан үргэлжлэхээр байгаа нь дийлэнх салбарын өсөлтийг сааруулах нөлөө үзүүлж байна. Нөгөө талаас цар тахлаас үүдэн тогтоосон өндөржүүлсэн бэлэн байдлын түвшин буурсантай холбоотойгоор худалдаа, үйлчилгээний салбарын өсөлтийн төсөөлөл өмнөхөөс нэмэгдэв. Уул уурхайн салбарын хувьд, хилийн боомтын хязгаарлалтаас шалтгаалан нүүрсний үйлдвэрлэл төдийлөн нэмэгдэхгүй, зэсийн баяжмал дахь алтны агууламж багасахаар байгаа нь салбарын өсөлтийг бууруулахад нөлөөллөө.

Ийнхүү энэ онд өсөлтийн төлөв саарсан суурь үеийн нөлөөгөөр 2023 оны эдийн засгийн өсөлт өмнөх төсөөлөлтэй харьцуулахад нэмэгдэж байна (Зураг II.9).

Зураг II.9

4 улирлын нийлбэр ДНБ-ий жилийн өсөлт



Эх сурвалж: Монголбанк

Уул уурхай: Уул уурхайн салбарын үйлдвэрлэл энэ онд буурч, 2023 оноос сэргэх хүлээлттэй байна. Үүнд Оюу толгойн ил уурхайгаас олборлох зэсийн баяжмал дахь алтны агууламж өмнөх оноос 3 дахин буурах, БНХАУ-ын хилийн боомтын хязгаарлалт удаан үргэлжлэх төлөвтэй байгаагаас нүүрс, төмрийн хүдэр, газрын тос зэрэг голлох эрдэс

Инфляцын тайлан 2022 оны 3 дугаар сар

бүтээгдэхүүний экспорт хязгаарлагдаж, улмаар нийт дүнгээр уул уурхайн салбарын үйлдвэрлэл энэ онд буурах төлөвтэй байна. Харин ирэх оноос нүүрсний үйлдвэрлэл хэвийн түвшинд хүрч сэргэх, Оюу толгойн зэсийн баяжмал, түүний алтны агууламж эргэн сайжрах, далд уурхайн үйлдвэрлэл эхлэх зэрэг нөлөөгөөр уул уурхайн салбарын өсөлт дунд хугацаанд сэргэх хүлээлттэй байна.

Хүснэгт II.1.1

Эдийн засгийн өсөлтийн төсөөлөл				
	2021	2022*	2023*	2024*
		төсөөлөл		
ДНБ-ий өсөлт	1.4	2.4 [0.5-4.4] ¹¹	5.9 [3.4-8.4]	6.5 [3.8-9.1]
Уул уурхайн	1.7	(-10.1) [(-12.0) - (-8.2)]	8.5 [6.1 - 11.0]	6.5 [3.9 - 9.2]
Уул уурхайн бус	1.4	4.5 [2.7-6.5]	5.6 [3.2-8.1]	6.5 [3.9-9.2]

Эх сурвалж: Монголбанк

Уул уурхайн бус: Гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэргийг бууруулсан нь зарим салбарын өсөлт сэргэхэд нөлөөлж байгаа хэдий ч ОХУ-Украины нөхцөл байдал нь хүлээгдээгүй шинэ эрсдэл бий болгосны зэрэгцээ хилийн боомтууд дээрх хязгаарлалт цаашид үргэлжлэхээр байгаа нь уул уурхайн бус салбарын өсөлтийг энэ онд хязгаарлаж байна. Тодруулбал, олон улсын харилцааны хурцадмал байдалтай холбоотойгоор дэлхийн зах зээл дэх газрын тосны үнэ, бусад түүхий эдийн үнэ өссөнөөр дотоодын үйлдвэрлэлийн зардал нэмэгдэж салбаруудын өсөлт саарахаар байна. Мөн бүс нутгийн ачаа, тээвэр удааширч, тээвэр логистикийн нөхцөл хүндрэхээр байгаа нь импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, улмаар өрхийн хэрэглээгээр дамжин худалдаа, үйлчилгээний салбарын идэвхжлийг бууруулах ба газар тариаланд шаардлагатай орц бүтээгдэхүүний нийлүүлэлт буурч, хүнсний үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлж болзошгүй.

¹¹ 30 хувийн магадлалтай итгэх интервал

Хүснэгт II.1.2

Эдийн засгийн өсөлтийн төлөвт гарсан өөрчлөлт (2022)

НИЙТ ЭРЭЛТ	
Хэрэглээ	Өмнөх төсөөллийн орчимд
<ul style="list-style-type: none"> Өнгөрсөн оны дундаас хөл хориог цуцалж, иргэдийн орлогыг дэмжих арга хэмжээг үргэлжлүүлж буй хэдий ч өрхийн хэрэглээ хараахан сэргээгүй байна. Түүнчлэн үнийн өсөлт, хөдөлмөрийн зах зээлийн удаан сэргэлттэй холбоотойгоор өрхийн хэрэглээ цар тахлын өмнөх үед хүрч сэргэх төсөөллийг хагас жилээр хойшлууллаа. 	
Хөрөнгө оруулалт	Өмнөх төсөөллийн орчимд
<ul style="list-style-type: none"> Нийт хөрөнгийн хуримтлал цар тахлын эхэнд буюу 2020 онд огцом хумигдсан бөгөөд түүнээс хойш харьцангуй тогтвортой сэргэж, хүлээлттэй нийцтэй байгаа бөгөөд 2022 оны төсөөлөл өмнөхөөс төдийлөн өөрчлөгдсөнгүй. Энэ онд төсвийн хөрөнгө оруулалт 60 гаран хувиар нэмэгдэж 4.9 их наяд төгрөг хүрэх бол бизнесийн зээлийн өсөлт өмнөх оноос бага зэрэг саарах төлөвтэй байна. 	
Цэвэр экспорт	Өмнөх төсөөллөөс буурсан
<ul style="list-style-type: none"> Оны эхний улиралд хилийн боомт дээрх уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн асуудал хэвээр үргэлжилж, экспорт бодит дүнгээр 40 орчим хувиар саарахаар байна. Харин оны сүүлийн 3 улиралд экспорт аажим нэмэгдэж, 2018 оны түвшиний хүрэх ба өнгөрсөн оны нам суурийг давах төлөвтэй байна. 	
НИЙТ НИЙЛҮҮЛЭЛТ	
Уул уурхай	Өмнөх төсөөллөөс буурсан
<ul style="list-style-type: none"> Оюу толгойн ил уурхайгаас олборлох зэсийн баяжмал дахь алтны агууламж өмнөх оноос 3 дахин буурах хүлээлт хэвээр хадгалагдаж байна. Нүүрс, төмрийн хүдэр, газрын тосны олборлолт экспортлох чадамжтайгаа уялдан потенциал түвшиндээ хүрэх боломж хязгаарлагдмал байна. 	
Уул уурхайн бус	Өмнөх төсөөллөөс буурсан
<ul style="list-style-type: none"> Хилийн боомтууд дээр үүсээд буй нөхцөл байдал өмнө хүлээгдэж байснаас илүү удаан хугацаанд үргэлжлэхээр байгаа нь төмөр, авто замын тээвэрлэлтийг сааруулж байна. Түүнчлэн, хилийн боомтын асуудал дотоодын боловсруулах үйлдвэрлэлд шаардагдах бараа материал, түүхий эдийн нийлүүлэлтийг доголдуулж байна. Барилга угсралтын өртөг өндөр байгаа тул бодит дүнгээр хийгдэх ажил төдийлөн нэмэгдэхээргүй байна. Эрчим хүчний төлбөр хөнгөлөлтүүдээс чөлөөлөгдснөөр хэрэглээ хэмнэгдэж эхэлж байна. 	


Эх сурвалж: Монголбанк

Өмнөх онтой харьцуулахад иргэдийн хөл хөдөлгөөн сүүлийн саруудад хурдацтай эрчимжиж, худалдаа, үйлчилгээ, мэдээлэл холбооны салбарууд сэргэх хандлага цаашид үргэлжлэх хүлээлттэй байна. Харин хилийн боомтын хязгаарлалт харьцангуй удаан үргэлжлэх, ачаа тээврийн саатлаас үүдэн түүхий эд, үйлдвэрлэлийн орцын нийлүүлэлт үргэлжлэн хязгаарлагдахаар байгаа нь боловсруулах, барилга болон тээврийн салбарын өсөлтийн төлөвийг сааруулж байна.

Ирэх онд цар тахлын тархалттай холбоотойгоор дахин хөл хорио тогтоохгүй, хилийн хязгаарлалтын асуудал шийдэгдэж, геополитикийн эрсдэлтэй холбоотой үүссэн нөхцөл байдал намжина гэж үзсэнээр эдийн засгийн идэвхжил алгуур сэргэх хүлээлттэй байна. Дунд хугацаанд гадаадын хөрөнгө оруулалт буурах нь уул уурхайн бус салбарын идэвхжилд сөргөөр нөлөөлөх хэдий ч түүхий эдийн үнийн түвшин тогтворжиж худалдааны нөхцөл сайжрах нь эдийн засгийн өсөлтийг дэмжих бөгөөд эдийн засаг цар тахлын уналтаас гарч, гадаад ба дотоод эдийн засгийн идэвхжил тогтворжино гэж үзлээ (Хүснэгт II.1.1).

Зураг III.1.3

Ажиллагчдын өсөлт, цалингийн бүлгээр




Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар

Ажил эрхлэлт, нийгмийн даатгал

Нийт ажил эрхлэлт IV улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 0.2%-иар нэмэгджээ. Үүнд уул уурхай, барилга, ХАА, зочлох үйл ажиллагаа, мэдээлэл холбоо, төрийн удирдлагын салбарт ажиллагчдын өсөлт голлон нөлөөлжээ. Нөгөөтэйгүүр, боловсруулах, худалдаа, санхүү даатгал, эрүүл мэнд, урлаг үзвэрийн салбарт албан хаагчид өмнөх оны мөн үетэй харьцуулахад буурсан байна (Зураг III.1.2).

Зураг III.1.2

Уул уурхай, барилга, ХАА, төрийн удирдлагын салбарт ажиллагчид өсчээ.



Эх сурвалж: УСХ

Нийгмийн даатгалд даатгуулагч нийт ажил эрхлэгчид өмнөх оны мөн үеэс 4.0%-иар өссөн бөгөөд цалингийн бүлгээр авч үзвэл сард 2 сая төгрөг болон түүнээс дээш цалинтай ажиллагчид өмнөх оны мөн үеэс 30 хувиар тэлжээ. Түүнчлэн, сард 1-2 сая төгрөгийн хооронд цалин авч буй ажиллагчид дунджаар 10 гаруй хувиар өссөн бол хөдөлмөрийн хөлснөөс дээш бөгөөд 1 сая төгрөгөөс доош орлоготой иргэд 6 орчим хувиар буурлаа (Зураг III.1.3).

Ажилгүйдэл

Энэ оны эхний 2 сарын байдлаар нийгмийн даатгалын сангаас 10.5 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмжийг 4.2 мянган хүнд олгоод байна. Хэдийгээр олгосон тэтгэмжийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.9%-иар өндөр байгаа ч тэтгэмж авсан иргэдийн тоо 9.2%-иар буурчээ. Ингэснээр нэг иргэнд ногдож буй сарын дундаж ажилгүйдлийн тэтгэмж өмнөх оны мөн үеэс 30%-иар нэмэгдэж, 2.5 сая төгрөгт хүрлээ (Зураг III.1.4).

Зураг III.1.4

Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ өссөн ч хүртээмж буурч байна.



Эх сурвалж: Нийгмийн даатгалын ерөнхий газар


Цалин, өрхийн орлого

Улсын дундаж цалин тайлант IV улиралд 1438.2 мянган төгрөг, медиан цалин 1068.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 7-8 хувиар нэмэгдсэн үзүүлэлт болж байна. Үүнтэй уялдаатайгаар өрхийн сарын дундаж

нийт орлого өмнөх оны мөн үеэс 15.3%-иар өсөж, 1642.9 мянган төгрөгт хүрчээ. Хэдийгээр нэрлэсэн орлого ийнхүү өссөн ч иргэдийн худалдан авах чадварыг илэрхийлэх үнийн нөлөөллийг арилгасан бодит орлогын үзүүлэлтүүд бууралттай байна. Тухайлбал, улсын дундаж бодит цалингийн индекс өмнөх оны мөн үеэс 4.4%-иар буурсан байна (Зураг III.1.5).

Зураг III.1.5

Бодит цалин сүүлийн 3 улирлын турш саарлаа.



Эх сурвалж: YCX

Эдийн засгийн голлох салбаруудаас зочид буудал ба зоогийн газар (30%), эрүүл мэнд (25%), мэдээлэл холбоо (17%), санхүү даатгал (17%)-ын салбарт ажиллагчдын дундаж цалин харьцангуй өндөр өсөлттэй байв. Харин уул уурхай (-3%), эрчим хүч (0%), урлаг үзвэр (3%), боловсрол (3%)-ын салбарт алба хаагчдын цалин төдийлөн өссөнгүй.

Байгууллагуудын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл нөхөрлөл (46-71%), хоршоо (11%), ХХК (10%), ТББ (10%)-уудад ажиллагчдын дундаж цалин өмнөх оны мөн үеэс хамгийн ихээр нэмэгджээ.

Бүтээмж, нэгж хөдөлмөрийн зардал

Хөдөлмөрийн бүтээмж¹³ сүүлийн улирлуудын дунджаар тогтворжиж байна. Ерөнхийдөө 2020 он гарснаас хойш цар тахлын жилүүдэд ажиллагчдын хөдөлгөөн


¹³ Нэг ажиллагчид ногдох дундаж ДНБ-ий хэмжээ.

Инфляцын тайлан 2022 оны 3 дугаар сар

болон эдийн засгийн идэвхжил эсрэг чиглэлд өөрчлөгдөх хандлага ажиглагдаж байгаа. Ажиллагчдын буурч байсан хандлага IV улиралд тогтворжсон байна. Эдийн засгийн голлох салбаруудаас уул уурхайн хөдөлмөрийн бүтээмж хурдацтай нэмэгдсэн хэвээр байгаа бол боловсруулах, худалдаа, үйлчилгээний салбаруудын бүтээмж 10-26%-аар өсжээ (Зураг III.1.6).

Зураг III.1.6

Хөдөлмөрийн дундаж бүтээмж өсөж байна.




Эх сурвалж: YCX, Монголбанк

Нэгж хөдөлмөрийн зардал¹⁴ сүүлийн улирлуудын дунджаар эргэн нэмэгдэх хандлагатай болж байна. Үүнд эдийн засгийн идэвхжил буурсан нь голлон нөлөөлсөн гэж үзэж байна (Зураг III.1.7).

Зураг III.1.7

Нэгж хөдөлмөрийн дундаж зардал буурч байна.



Эх сурвалж: YCX, Монголбанк

¹⁴ Нэгж ДНБ-д ногдох дундаж хөдөлмөрийн өртөг буюу цалин.

III.2 Мөнгө, санхүүгийн зах зээл


III.2.1 Мөнгө, зээлийн үзүүлэлтүүд

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт саарч, харин банкуудын зээлийн өсөлт алгуур нэмэгдэв. Банкны системийн хадгаламжийн долларжилт сүүлийн саруудад тогтвортой, зээлийн долларжилт буурлаа. Банкуудын зээлийн шалгуур, нөхцөл суларч, иргэд болон аж ахуйн нэгжүүдийн зээлийн эрэлт нэмэгдсэн байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг зээлийн өсөлт болон Засгийн газрын цэвэр зээл (ЗГЦЗ) бүрдүүлж байна. Мөнгөний нийлүүлэлт 2022 оны 1 дүгээр сарын байдлаар өмнөх жилийн мөн үеэс 10.6 хувиар өсөхөд зээлийн өсөлт 16.5 нэгж хувь, ЗГЦЗ 5.1 нэгж хувийг бүрдүүлсэн байна (Зураг III.2.1.1).

Зураг III.2.1.1

M2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, актив тал



Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн зээлийн өсөлт 2021 оны 1 дүгээр улирлаас эхлэн нэмэгдсэн хэвээр байна. Өмнөх оны эхний 3 улиралд “Эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө”-ний нөлөөгөөр банкны системийн зээлийн өсөлт эрчимжиж байсан бол оны сүүлийн саруудад иргэдийн хэрэглээ болон хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт нэмэгдэж эхэлсэн нь нийт зээлийн өсөлтөд эерэг нөлөө үзүүллээ.


Түүнчлэн 2021 онд төсвийн алдагдлын дийлэнх хэсгийг дотоод банкны систем дэх нөөц эх үүсвэрээс санхүүжүүлсэн нь

Инфляцын тайлан 2022 оны 3 дугаар сар

мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэв. Тодруулбал, төсвийн алдагдал 2021 онд 2.9 их наяд төгрөгт хүрч, үүний 2.2 орчим их наяд төгрөгийг дотоод банкны систем дэх хуримтлалаас санхүүжүүлсэн байна (Зураг III.2.1.1).

Зураг III.2.1.2

M2 мөнгөний жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, пассив тал




Эх сурвалж: Монголбанк

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлт төгрөгийн харилцах, хадгаламжийн эх үүсвэрээс голлон бүрдэж байна. Тодруулбал, мөнгөний нийлүүлэлт 10.6 хувиар өссөн бөгөөд төгрөгийн хадгаламжийн өсөлт 4.7 нэгж хувь, төгрөгийн харилцахын өсөлт 7.5 нэгж хувийг бүрдүүлэв. Харин гадаад валютын хадгаламж -2.3 нэгж хувь, гадаад валютын харилцах 0.2 нэгж хувийн нөлөөг тус тус үзүүлжээ. Улмаар банкны системийн эх үүсвэрийн долларжилт 2022 оны 1 дүгээр сард 23.8 хувь байгаа нь өмнөх оны мөн үеэс 4.8 нэгж хувиар буурсан бол өмнөх сараас 0.4 нэгж хувиар нэмэгдсэн дүн юм. (Зураг III.2.1.3).

Зураг III.2.1.3

Банкуудын зээл, хадгаламжийн долларжилт




Эх сурвалж: Монголбанк

Банкны системийн зээлийн үлдэгдэл¹⁵ 2022 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 3.7 их наяд төгрөгөөр нэмэгдэж 20.8 их наяд төгрөгт хүрч, жилийн **21.9** хувиар өссөн байна. Эдийн засгийн салбараар нь харвал үйлчилгээ, худалдаа, боловсруулах, тээвэр агуулах болон уул уурхайн салбарын зээлүүд нь нийт зээлийн өсөлтийг голлон бүрдүүлэв (Зураг III.2.1.4). Түүнчлэн сүүлийн саруудад иргэдийн хэрэглээ болон хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт эрчимжиж байна. Зээлийн зориулалтаар нь харвал 10 их наядын цогц төлөвлөгөөтэй холбоотойгоор бизнесийн зээлийн өсөлт 20.3 хувьд хүрч, хэрэглээ болон хадгаламж барьцаалсан зээл өмнөх жилийн мөн үеэс 19.3 хувиар өссөн байна.

Зураг III.2.1.4

Арилжааны банкуудын зээлийн жилийн өсөлтийн бүрэлдэхүүн, салбаруудаар




Эх сурвалж: Монголбанк

Валютын төрлөөр нь авч үзвэл төгрөгийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 24.8 хувиар нэмэгдэж, гадаад валютын зээлийн үлдэгдэл 6.1 хувиар буурлаа.

Зураг III.2.1.5

Банкны системийн нийт зээл олголт, эргэн төлөлт (Тухайн жилд өсөн нэмэгдэх)



Эх сурвалж: Монголбанк

Банкны системээс 2021 онд нийт 28.3 их наяд төгрөгийн зээл олгосон нь 2020 оноос 8.5 их наяд төгрөгөөр буюу 43.1 хувиар өссөн байна. Харин 2022 оны 1 дүгээр сард 2.4 их наяд төгрөгийн зээл олгосон нь өмнөх оны мөн үеэс 900 орчим тэрбум төгрөгөөр буюу 63.7 хувиар нэмэгдлээ. Харин зээлийн эргэн төлөлт 2022 оны 1 дүгээр сард 2.1 их наяд төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 700

¹⁵ Үнэт цаасжуулсан ипотекийн зээлийн нөлөөг хассан.


тэрбум төгрөг буюу 45.8 хувиар өссөн дүн юм.

“Банкны зээлийн төлөв” түүвэр судалгааны 2021 оны 4 дүгээр улирлын үр дүнг тоймлон авч үзвэл тайлант улиралд ихэнх банкууд зээлийн нөхцөл болон шалгуураа бага зэрэг сулруулсан байна. Зээлийн шалгуур буурахад банкуудын эрсдэл даах чадвар сайжирсан нь голлон нөлөөлжээ. Зээлийн хүү буурах, хүүний бус шимтгэл болон хураамжийг багасгах, зээлийн хэмжээ, барьцаа хөрөнгийн үнэлгээг нэмэгдүүлэх зэргээр зээлийн нөхцөл суларсан байна. Харин нийт банкуудын хувьд 2021 оны 4 дүгээр улиралд ААН болон иргэдийн зээлийн эрэлт бага зэрэг өслөө. Түүнчлэн, ААН-үүдийн нийт зээлийн хүсэлтийн 64 хувь, иргэдийн зээлийн хүсэлтийн 92 хувийг шийдвэрлэж зээл олгосон байна.

2022 оны 1 дүгээр улиралд том болон жижиг банкууд зээлийн нөхцөл болон шалгуурыг дахин бага зэрэг сулруулах төлөвтэй байна. Банкны систем дэх ААН, иргэдийн зээлийн эрэлт бага зэрэг өсөж байгаагаас зээлийн нийлүүлэлт (ХАА, боловсруулах, худалдаа, үйлчилгээ, уул уурхай, барилга, хэрэглээний зээл) мөн өсөх хүлээлттэй байна.¹⁶

Зураг III.2.1.6

Банкны системийн нийт зээлийн үлдэгдлийн бүтэц, эдийн засгийн салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

¹⁶ “Банкны зээлийн төлөв” түүвэр судалгааны тайлан (Банкуудаас 2022 оны 1 дүгээр сарын 13-ны өдрөөс 20-ны өдрийн хооронд санал асуулга хэлбэрээр авсан)


Инфляцын тайлан 2022 оны 3 дугаар сар

Худалдааны салбарын зээлийн өсөлт хурдацтай нэмэгдэж, нийт зээлийн үлдэгдлийн бүтэц өөрчлөгдөв. Тухайлбал, 2022 оны 1 дүгээр сарын байдлаар худалдааны салбарын нийт зээлд эзлэх хувь өмнөх жилийн мөн үеэс 3.2 нэгж хувиар нэмэгдсэн бол уул уурхай, барилга, боловсруулах, хэрэглээ болон хадгаламж барьцаалсан зээлийн нийт зээлд эзлэх хувь 3.4 нэгж хувиар буурлаа.

Банкны системийн зээлийн чанар өмнөх жилээс төдийлөн өөрчлөгдөөгүй, харин зээл олголт огцом өсөж, анхаарал хандуулах болон чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь буурлаа. Чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар өсөж чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 1.7 нэгж хувиар буурч 2022 оны 1 дүгээр сарын байдлаар 10 хувьд хүрэв. Харин анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл 2022 оны 1 дүгээр сард жилийн 20.9 хувиар буурав (Зураг III.2.1.7). Үүнд, боловсруулах салбарын анхаарал хандуулах зээл нэмэгдсэн бол худалдаа, барилга болон үйлчилгээний салбарын анхаарал хандуулах зээл буурсан нь нөлөөллөө. Анхаарал хандуулах зээлийн нийт зээлд эзлэх хувь 2022 оны 1 дүгээр сарын байдлаар 5 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.7 нэгж хувиар буурсан байна.

Зураг III.2.1.7

Банкуудын чанаргүй зээлийн жилийн өсөлт, эдийн засгийн салбаруудаар



Эх сурвалж: Монголбанк

III.2.2 Хүү

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2021 оны 12 дугаар сарын ээлжит хурлаар бодлогын хүүг 6 хувьд хэвээр хадгалах, 2022 оны 1 дүгээр сард ээлжит бус хурлаар бодлогын хүүг 0.5 нэгж хувиар өсгөж 6.5 хувьд хүргэх шийдвэр гаргалаа. Тайлант хугацаанд банк хоорондын захын хүүнүүд хүүний коридорын голч буюу бодлогын хүүний орчимд тогтвортой байв. Хөнгөлөлттэй хүүтэй зээлүүдийн нөлөөг хасч тооцсон банкны системийн төгрөгийн зээлийн хүү сүүлийн саруудад 14.5 хувь орчимд тогтвортой хадгалагдлаа.

Зураг III.2.2.1

БХЗ-ын хэлцлийн хүү



Эх сурвалж: Монголбанк

Банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү 2022 оны 1 дүгээр сард өмнөх сараас 0.06 нэгж хувиар буурч 6.11 хувьд хүрэв. Үүнд ТБҮЦ барьцаалсан репо хэлцлийн хүү 0.09 нэгж хувиар, банк хоорондын хадгаламжийн хүү 0.62 нэгж хувиар буурч 6.18 хувьд хүрсэн нь нөлөөллөө (Зураг III.2.2.1).


Энэ оны 1 дүгээр сард банкуудын шинээр татсан төгрөгийн хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 0.65 нэгж хувиар буурч 7.25 хувьд хүрсэн бол шинээр олгосон төгрөгийн зээлийн дундаж хүү (хөнгөлөлттэй хүүтэй зээлүүдийг хасч тооцвол) 1 нэгж хувиар буурч 14.4 хувьд хүрлээ. Харин хөнгөлөлттэй хүүтэй зээлийг оруулж тооцвол нийт төгрөгийн зээлийн хүү 1.1 нэгж хувиар буурсан буюу 14.1 хувьтай байна. Улмаар

Инфляцын тайлан 2022 оны 3 дугаар сар

төгрөгийн зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх оны мөн үеэс 0.45 нэгж хувиар буурч 6.83 хувьд хүрэв (Зураг III.2.2.2).

Зураг III.2.2.2

Шинээр олгосон зээлийн болон шинээр татсан хадгаламжийн хүү



Эх сурвалж: Монголбанк

Шинээр олгосон гадаад валютын зээлийн хүү болон шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүүний зөрүү буурлаа. Шинээр олгосон гадаад валютын зээлийн дундаж хүү 2022 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 0.75 нэгж хувиар буурч 8.28 хувьд хүрсэн бол шинээр татсан гадаад валютын хадгаламжийн хүү өмнөх оны мөн үеэс 0.09 нэгж хувиар өсөж 2.09 хувьд хүрснээр гадаад валютын зээл, хадгаламжийн хүүний зөрүү өмнөх оны мөн үеэс 0.84 нэгж хувиар буурч 6.19 хувьд хүрэв (Зураг III.2.2.2).

Хүснэгт III.2.2.1

Шинээр олгосон зээлийн хүү (₮), зээлдэгчдээр

Хувь, %	2021.01 сар	2022.01 сар
Зээлийн хүү (хөнгөлөлттэй зээлийг оруулснаар)	15.2	14.1
Зээлийн хүү	15.4	14.4
1. Улсын байгууллага	3.5	2.0
2. Хувийн байгууллага	15.3	13.9
Үүнд: ААН-ийн ЖДҮ	13.0	13.8
3. Санхүүгийн байгууллага	15.7	16.2
4. Иргэд	16.1	13.9
Үүнд: Иргэдийн ЖДҮ	15.7	14.6
Хэрэглээ, хад. барь	17.1	14.2
5. Бусад байгууллага ¹⁷	13.8	1.0

Эх сурвалж: Монголбанк

¹⁷ Иргэд, олон нийтэд үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн бус болон ашгийн төлөө бус байгууллагууд


II.2.3 Валютын ханш

Сүүлийн нэг жил гаруй хугацаанд ам.долларын ханш 2850 төгрөгийн орчимд тогтвортой байлаа (Зураг III.2.3.1). Гэвч 2022 оны 2 дугаар сараас эхлэн төгрөгийн ам.доллартой харьцах ханш сулрах хандлага ажиглагдаж байна.

Тайлант улиралд импорт өссөн хэдий ч экспортын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс нэмэгдэн худалдааны тэнцэл ашигтай гарсан нь ханш харьцангуй тогтвортой хадгалагдахад нөлөөлөв. Харин 2022 оны 1-р улиралд ОХУ-Украины нөхцөл байдал нь төгрөг төдийгүй бусад валютуудын ханш ам.долларын эсрэг сулрахад нөлөөлөв. Энэ нь экспортын хэмжээ бага байгаатай давхцсан нь зах зээлд оролцогчдын итгэлд сөргөөр нөлөөллөө.

Зураг III.2.3.1

Төгрөгийн ам.доллартай харьцах ханш



Эх сурвалж: Монголбанк


Гадаад худалдааны эргэлтээр жигнэж тооцсон төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш (NEER) 2020 оны сүүлийн хагасаас эхлэн суларсан бөгөөд ханшийн сулрах хурд 2021 оны сүүлийн хагаст удаашран оны эцэст 0.1 хувиар чангарчээ. Энд сүүлийн 2 улирал дараалан евро ам.долларын эсрэг чангарсан нь голлон нөлөөлсөн бөгөөд 2021 оны эцэст жилийн 8.1 хувиар чангарсан байна. 2022 оны 1 дүгээр сард төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш өмнөх оны мөн үеэс 2.2 хувиар суларлаа. Үүнд төгрөгийн ханш оны эхний сард юанийн эсрэг жилийн 1.6 хувиар

Инфляцын тайлан 2022 оны 3 дугаар сар

суларсан, мөн еврогийн эсрэг чангарах хурд саарч, өмнөх онтой харьцуулахад 7.7 хувиар чангарсан нь голлон нөлөөллөө. Харин төгрөг ам.доллар болон рублийн эсрэг 1-р сард өөрчлөлт багатай байв.

Зураг III.2.3.2

Төгрөгийн гол валютуудтай харьцах ханш болон нэрлэсэн үйлчилж буй ханшийн (NEER) жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Бодит ханш 2021 оны сүүлийн хагасаас эхлэн дотоод харьцангуй үнийн өсөлтөөс шалтгаалан чангарсан байна. Тодруулбал, төгрөгийн нэрлэсэн ханш оны эцэст 0.1 хувиар чангарч, гадаад үнэтэй харьцуулахад дотоод үнэ 12.2 нэгж хувиар илүү өссөнөөр бодит ханш 2021 оны 12 дугаар сард өмнөх оны мөн үеэс 12.3 хувиар чангарав (Зураг III.2.3.3).

Зураг III.2.3.3

Төгрөгийн бодит ханшийн жилийн өөрчлөлт



Эх сурвалж: Монголбанк

Төгрөгийн харьцангуй өгөөж сүүлийн 1 жилийн турш эерэг түвшинд хадгалагдаж,

төгрөгийн ханшийн өөрчлөлтийг даган тогтвортой байна. Тайлант улиралд өгөөж жилийн 5.4 хувьтай байв (Зураг III.2.3.4). Ийнхүү төгрөгийн харьцангуй өгөөж харьцангуй өндөр түвшинд хадгалагдаж байгаа нь төгрөгийн хадгаламжийн хэмжээ нэмэгдэж, валютын хадгаламжийн хэмжээ буурах шалтгаан болжээ. Тодруулбал, төгрөгийн хадгаламж 2021 оны 12 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 12.2 хувиар өссөн бол долларын хадгаламж 14.4 хувиар буурсан байна.

Зураг III.2.3.4

Төгрөгийн харьцангуй өгөөж



Эх сурвалж: Монголбанк

III.2.4 Хөрөнгийн зах зээл

Тайлант улиралд орон сууцны үнэ үргэлжлэн өссөн бол хөрөнгийн захын үнэлгээ 2021 оны эцэст түүхэн дээд хэмжээнд хүрч, ТОП-20 индекс өндөр түвшинд хадгалагдлаа.

Орон сууцны зах зээл

Тэнхлэг зууч ХХК-аас мэдээлдэг орон сууцны үнийн индекс (ОСҮИ)-ийн өсөлт 2021 оны сүүлийн улиралд эрчимжлээ¹⁸. Тодруулбал, ОСҮИ өмнөх улирлаас 3.3 хувиар, өмнөх оны мөн үеэс дунджаар 14.8 хувиар өссөн бөгөөд шинэ орон сууцны үнэтэй харьцуулахад хуучин орон сууцны үнэ хурдацтай нэмэгджээ. ҮСХ-ноос мэдээлдэг түрээсийн үнийн өсөлт мөн эрчимжиж, 2021 оны 4 дүгээр улиралд өмнөх улирлаас 7.0


¹⁸ Тайлант улиралд ҮСХ-ноос ОСҮИ-ийн мэдээллийг зарлаагүй.

Инфляцын тайлан 2022 оны 3 дугаар сар

хувиар, өмнөх оны мөн үеэс 11.6 хувиар өссөн байна (Зураг III.2.4.1).

Зураг III.2.4.1

Орон сууцны үнэ ба түрээсийн үнийн өсөлт



Эх сурвалж: ҮСХ, Тэнхлэг-Зууч

Эдийн засгийг дэмжих бодлогын хүрээнд 2021 онд орон сууцны ипотекийн зээлийн хүүг 6 хувь болгож бууруулсны зэрэгцээ ипотекийн зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлсэн нь орон сууцны эрэлтийг нэмэгдүүлэх гол хүчин зүйл байв. Тухайлбал, 2021 онд нийт 18,178 зээлдэгчид орон сууцны ипотекийн зээл олгосон¹⁹ нь өмнөх оноос 61.1 хувиар өссөн үзүүлэлт юм. Нөгөө талаас орон сууцны барилгын өртгийн индекс (БӨИ) 2021 оны 4 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 39 хувиар өсөж, өндөр түвшинд хадгалагдаж байгаа (Зураг III.2.4.2) нь орон сууцны үнийн өсөлтийг бий болгож байна. Хилийн хязгаарлалт нь импортоор орж ирдэг барилгын материалын нийлүүлэлт саатах, удаашрах, хөнгөлөлттэй хүүтэй орон сууцны зээл эрчимжсэн зэрэг нь үнэ өсөхөд нөлөөлж, улмаар орон сууцны барилгын төслүүд хойшлох, шинэ орон сууцны үнэ өсөх гол шалтгаан болж байна.


¹⁹ Эх сурвалж: Монголбанк. Банкны өөрийн эх үүсвэрийн болон ОСИСТТБХ-ийн эх үүсвэрийн зээл.

Хүснэгт III.2.4.1

		2021-Q3	2021-Q4
Орон сууцны захын үзүүлэлтүүд			
Орон сууцны үнийн өсөлт, %			
Тэнхлэг Зууч	улирлаар	6.7	3.3
	жилээр	9.7	14.8
Түрээсийн үнийн өсөлт, %	улирлаар	2.9	7.0
	жилээр	6.0	11.6

Эх сурвалж: УСХ, Тэнхлэг-Зууч

Зураг III.2.4.2




Эх сурвалж: УСХ

“Тэнхлэг зууч” ХХК-ий ОСҮИ-ийг ашиглан орон сууцны захын төлөвийг илтгэх харьцаа үзүүлэлтүүдийг тооцлоо. 2021 оны 4 дүгээр улиралд өрхийн дундаж орлого өмнөх улирлаас 0.4 хувиар өсөж²⁰, орон сууцны үнийн өсөлтийг даваагүйгээс үнэ-орлогын харьцаа өмнөх улирлын түвшнээс өсөв. Харин түрээсийн үнийн улирлын өсөлт өндөр байсан нь өмнөх улирлуудад эрчимжиж байсан үнэ-түрээсийн харьцаа эргэн буурахад хүргэлээ. Орон сууцны захын эрэлт харьцангуй өндөр байгаа хэдий ч өрхийн орлого алгуур сэргэж, зардлын шалтгаанаар үнэ өсөж байгаагаас орон сууц худалдан авах чадвар төдийлөн сэргэхгүй байна (Зураг III.2.4.3).

²⁰ Эх сурвалж: УСХ

Зураг III.2.4.3



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Хөрөнгийн зах зээл

Хөрөнгийн захын идэвх 2021 оны туршид эрчимжиж 12 дугаар сарын дунджаар ТОП-20 индекс 41,668.8 нэгжид хүрсэн нь оны эхнээс 2 дахин өссөн үзүүлэлт боллоо. Мөн зах зээлийн үнэлгээ түүхэн дээд хэмжээ буюу 5.98 их наяд төгрөгт хүрэв. Харин он гарснаар хөрөнгийн захын идэвхжил харьцангуй тогтворжсон бөгөөд 2022 оны 1-р сарын дунджаар ТОП-20 индекс 42,447.6 нэгжид хүрч өмнөх сарын дунджаас 1.9 хувиар өсчээ (Зураг III.2.4.4).

Зураг III.2.4.4



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж


Банкны хадгаламжийн хүү буурсан, инфляц өссөн, хөрөнгийн зах зээлд арилжаалагдах бүтээгдэхүүний төрөл нэмэгдсэн зэргээс

шалтгаалан хөрөнгийн зах зээлд оролцогчдын идэвх нэмэгдэж, хөрөнгийн захын үзүүлэлтүүд өндөр түвшинд хадгалагдахад нөлөөлж байна.

Харин 2021 онд нийт 1,414 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн нь өмнөх оноос 20.6 хувиар өссөн үзүүлэлт бөгөөд нийт арилжааны 74.1 хувийг компанийн бондын арилжаа, 21.6 хувийг хувьцааны арилжаа бүрдүүлжээ. Он гарсаар 2022 оны 1 дүгээр сард нийт 42.1 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 2.8 дахин өндөр үзүүлэлт юм.

Зураг III.2.4.5

Хөрвөх чадварын харьцаа²¹



Эх сурвалж: УСХ, Монголбанк

Үүнээс 37.7 тэрбум төгрөг буюу 89.3 хувийг хувьцааны арилжаа бүрдүүлсэн бөгөөд арилжааны үнийн дүнгээр “Ард санхүүгийн нэгдэл”, “АПУ”, “Монос хүнс” компаниуд тэргүүлсэн бол тоо ширхэгээр “Монос хүнс”, “Мандал даатгал”, “Говь” компаниуд тэргүүлжээ. Хөрөнгийн захын хөрвөх чадварын харьцааг хувьцааны арилжааны хувьд тооцоолоход 2022 оны эхний сард 7.8 хувьд хүрч өмнөх улирлын дунджаас 0.9 нэгж хувиар буурсан хэдий ч өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.8 дахин өндөр үзүүлэлт болж байна (Зураг III.2.4.5).

III.3 Нэгдсэн төсөв болон Засгийн газрын өр

Нэгдсэн төсөв: Төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2021 онд батлагдсан дүнгээс 600

Инфляцын тайлан 2022 оны 3 дугаар сар

орчим тэрбум төгрөгөөр давж, зардал бүрэн зарцуулагдсанаар нэгдсэн төсөв 2.9 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа. Төсвийн орлого төлөвлөгөөнөөс давсан нь 1/ Оюу толгой компаниас 1 их наяд төгрөгийн орлого нэмж бүрдсэн, 2/ НДШ 2021 оны 7 дугаар сараас эхлэн хөнгөлөлтгүй хувь хэмжээгээр төлөгдөж эхэлсэн, 3/ НӨАТ-ын орлого төлөвлөгөөнөөс өндрөөр биелсэнтэй холбоотой байв.

Хүснэгт III.3.1

Төсвийн үзүүлэлтүүд

Их наяд төгрөг	2021		2022	
	Гүй.	Бат.	Гүй.	Гүй. хувь
Нийт орлого	14.3	16.4	2.6	94.9
Сангийн орлого	1.6	0.6	0.1	266
Тэнцвэржүүлсэн орлого	12.7	15.8	2.5	92.2
Татварын орлого	11.3	13.9	2.3	93.7
Татварын бус орлого	1.4	1.8	0.1	69.9
Нийт зардал	15.6	18.2	2.4	69.9
Анхдагч зардал	14.8	17.2	2.4	71.5
Хүүний зардал	0.8	1.0	0.1	43.4
Нийт тэнцэл	-1.3	-1.7	0.1	
ДНБ-д эзлэх хувь	-3.2	-3.7	0.3%	
Тэнцвэржүүлсэн тэнцэл	-2.9	-2.4	0.0	
ДНБ-д эзлэх хувь	-6.9	-5.1	0.1%	
Анхдагч тэнцэл	-2.1	-1.4	0.1	
ДНБ-д эзлэх хувь	-4.9	-3.1	0.2%	

Эх сурвалж: Сангийн яам

Энэ оны эхний 2 сард төсвийн тэнцвэржүүлсэн орлого өмнөх оны мөн үеэс 51.7 хувиар илүү төвлөрч 2.5 их наяд төгрөгт, төсвийн зардал 40.0 хувиар өсөж 2.4 их наяд төгрөгт хүрч биелснээр төсвийн тэнцэл 32 тэрбум төгрөгийн эерэг дүнтэй байв (Хүснэгт III.3.1).

Тэнцвэржүүлсэн орлого 2022 онд: Төсвийн тэнцвэржүүлсэн орлого батлагдсан төсвийн дагуу өмнөх оноос 24 орчим хувиар огцом өсөхөөр байна (Зураг III.3.1). Үүнд; 1/ энэ онд хатуу хөл хорио тогтоохгүй, 2/ нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ хөнгөлөлтгүй буюу 26 хувиар хэрэгжиж байгаа, 3/ “Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ (Шигтгээ 2) хэрэгжүүлж эхлэхтэй холбоотойгоор хуучнаар “Ирээдүйн өв сан”-д бүртгэгддэг байсан орлогыг тэнцвэржүүлсэн төсвийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ)-т бүртгэх болсон нь гол

²¹ “ЭТТ бонд”-ын арилжааны дүнг хасч дүрслэв.

нөлөөтэй байна. Гэвч, ОХУ-Украины нөхцөл байдалтай холбоотойгоор төсвийн орлого батлагдсан дүнгээс дутах эрсдэл өндөр байна.

ШИГТГЭЭ 2. ИРЭЭДҮЙН ӨВ САН (ИӨС)

Төсвийн хүрээний мэдэгдэл

Харин Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд болох “АЛСЫН ХАРАА-2050”, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээ хэрэгжүүлж, хүүхдийн хуримтлал бий болгоход шаардагдах тогтолцоог бүрдүүлэхээр тусгаж, “Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулиар ИӨС-гийн орлогыг тэнцвэржүүлсэн төсвийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ)-т бүртгэж, цаашлаад тус сангийн тухайн жилийн орлогын эх үүсвэрийг төсвийн тухай хуульд заасан дүнгээр арилжааны банканд дахь хүүхдийн нэрийн дансанд сар бүр хуримтлуулахаар өөрчлөлт оруулжээ. 2022 оны байдлаар сар бүр хүүхдийн нэрийн дансанд байрших хадгаламжийн дүнг 100’000 төгрөгөөр тогтоов.

Мөн хүүхдийн эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсвэл хүсэлт гарган сарын хадгаламжаас дараах хувиар тооцож мөнгөн хэлбэрээр бэлнээр авах эрхтэй гэжээ. Үүнд,


- 2022.01.01-2022.07.01: 100 хувь
- 2022.07.01-2022.12.31: 50 хувь
- 2023 он: 40 хувь

2024 оноос хойш: 30 хувь.

“Ирээдүйн өв сангийн тухай” хууль нөхөн сэргээгдэхгүй эрдэс баялгаас төсөвт төвлөрүүлсэн орлогыг одоогийн болон хойч үеийнхэнд тэнцвэртэй хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх зорилготой бөгөөд үүний дагуу ИӨС-г 2017 онд байгуулсан. “Ирээдүйн өв сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай” хуульд заасны дагуу 2017-2019 оны хооронд Хүний хөгжил санд хуримтлагдсан өр болох 1.0 их наяд төгрөгийг ИӨС-гаас бүрэн барагдуулснаар 2019 оноос эрдэс баялгаас олсон орлогоос хуримтлал бий болгож эхлэв. ИӨС-гаас 2030 он хүртэл сангийн хөрөнгийг удирдахтай холбоотой зардал болон хөндлөнгийн аудитын зардлыг санхүүжүүлэхээс бусад байдлаар зарцуулалт хийхгүй байх хуулийн заалттай байв.

Зураг III.3.1

Төсвийн орлогын бүтэц




Эх сурвалж: Сангийн яам

Нийт зардал, цэвэр зээл 2022 онд: Цар тахлын үед иргэдийн орлогыг дэмжих зорилгоор нэг удаагийн тэтгэмж, урамшуулал, хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж болон халамжийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлсэн дүнгээр олгох зэрэг арга хэмжээ хэрэгжүүлснээр 2021 онд төсвийн нийт зардлын 47% орчимыг²² татаас, шилжүүлгийн зардал дангаар эзэлж байжээ. Хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжийг 100'000 төгрөг хэвээр үлдээх шийдвэртэй холбоотойгоор дээрх хандлага 2022 онд хэвээр хадгалагдахаар байна. Мөн энэ оны 1 дүгээр сард эмнэлгүүдэд шилжүүлэх урсгал зардал, эмийн үнийн хөнгөлөлт, Ковид-19 тусламж үйлчилгээний шилжүүлэг өндөр дүнгээр зарцуулагдсан нь татаас, шилжүүлгийн зардал өндөр гарахад нөлөөлөв (Зураг III.3.2).

Төсвийн хөрөнгийн зардал 68 орчим хувиар нэмэгдэх төлөвлөгөөтэй бөгөөд эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 43 хувиар өндөр зарцуулагдав.

Зураг III.3.2

Төсвийн зардлын бүтэц



Эх сурвалж: Сангийн яам

Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр: 2021 оны урьдчилсан гүйцэтгэлээр өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын нийт өр нэрлэсэн ДНБ-ий 51.3 хувьтай гарчээ (Хүснэгт III.3.2).

Хүснэгт III.3.2

Өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн Засгийн газрын өр болон зээлийн үйлчилгээний төлбөр

	2020	2021	2022*
	Гүй.	Урьд. Гүй.	ТХМ
тэрбум төгрөг			
Засгийн газрын нийт өр (ӨҮЦ)	23024	22056	31439
ДНБ-д эзлэх хувь	62.3	51.3	67.2
Өрийн хязгаар	70.0	70.0	70.0
Зээлийн үйлчилгээний төлбөр	959	828	959
Төсвийн орлогод эзлэх хувь	10.2	6.5	6.1
Төсвийн тэнцэл	-4539	-2909	-2387
ДНБ-д эзлэх хувь	-12.2	-6.6	-5.1

Эх сурвалж: Сангийн яам

²² 2010-2020 оны дундаж 32 хувь

IV. ЭДИЙН ЗАСГИЙН ГАДААД ОРЧИН

IV.1 Эдийн засгийн гадаад орчны төсөөлөл

Гадаад эрэлт: БНХАУ, АНУ, Евро бүсийн 2022 оны өсөлтийн төлөв өмнөх төсөөллөөс муудаж, глобал эдийн засгийн өсөлтийн төлөв муудлаа. Үүнд цар тахлын нөхцөл байдал, БНХАУ-ын өсөлт саарах төлөв, ОХУ-Украины нөхцөл байдал, хүлээлтээс давсан инфляц, мөнгөний бодлого хурдтай нормалчлагдах зэрэг нь голлон нөлөөлж байна. (Зураг IV.1.1).

Зураг IV.1.1

Гадаад эрэлт өмнөх төсөөллөөс муудлаа.



Эх сурвалж: ОУВС, Блүмберг, Рубини, EIU
Гадаад эрэлтийг БНХАУ 90%, Евро бүс 8%, ОХУ 2% гэж тооцов.

Манай гадаад худалдааны гол түнш БНХАУ “Тэг-КОВИД” бодлогоо энэ оны турш үргэлжлүүлэх төлөвтэй болсон нь БНХАУ-ын хэрэглээ, аж үйлдвэрлэл, тээвэр, логистикт сөргөөр нөлөөлөхөөр байна. БНХАУ-ын эрх баригчид оны эхний хагаст төсөв, мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлж, дотоод эрэлт, өсөлтийг дэмжихээр байгаа хэдий ч БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын хүндрэл эдийн засагт өмнө нь хүлээж байснаас илүү хүчтэй нөлөөлөхөөр байгаа тул өсөлтийн төлөв нь муудлаа.

ОХУ-Украины нөхцөл байдал болон Барууны улс орнуудын ОХУ-т тавьсан эдийн засгийн хориг арга хэмжээний нөлөөгөөр ОХУ-ын эдийн засаг энэ онд өмнөх төсөөллөөс огцом буурч, агших төлөвтэй боллоо. Мөн ОХУ-тай хийх гадаад худалдаа доголдох, эрчим хүч, түүхий эдийн үнэ өсөж, үйлдвэрлэлийн зардал нэмэгдэх нөлөөгөөр Евро бүсийн эдийн засгийн төлөв муудлаа.

Дунд хугацаанд улс орнууд цар тахлын нөхцөлд дасан зохицож, төсөв, мөнгөний бодлогууд нормалчлагдан, эдийн засгийн өсөлт урт хугацааны хэвийн түвшиндээ тогтворжих хүлээлт хэвээр байна. Төсөөллийн хугацаанд ОХУ-Украины мөргөлдөөний цаашдын өрнөл, энэ нь дэлхийн эдийн засаг, санхүүгийн зах зээл, түүхий эдийн үнээр дамжин манай гадаад худалдаанд хэрхэн нөлөөлөх нь гадаад орчны гол тодорхой бус байдал болж байна.

Гадаад инфляц: БНХАУ-ын инфляцын төсөөлөл өмнөхийн орчимд, харин АНУ, Европын холбоо, ОХУ-ын хувьд төсөөлөл нэмэгдсэн байна. Ийнхүү манай гадаад инфляцын төсөөлөл нэмэгдлээ. Дэлхийн зах зээл дээрх хүнсний үнэ, эрчим хүчний үнэ болон түүхий эдийн үнэ өмнөхөөс төсөөллөөс нэмэгдсэн, ажиллах хүчний хомстол, нийлүүлэлтийн гинжин хэлхээ, тээвэр логистик дэх доголдолтой холбоотой үйлдвэрлэлийн үнэ үргэлжлэн өссөн нь гадаад инфляц өмнөх төсөөллөөс өсөхөд голлон нөлөөлөв. Цаашлаад эрчим хүчний үнэ үргэлжлэн өсөх, нийлүүлэлтийн доголдол хадгалагдах тохиолдолд зарим улс орнууд стагфляцад²³ орох эрсдэлтэй байна.

Гадаад хүү: АНУ-ын инфляц зорилтот түвшнээс өндөрт илүү удаан хугацаанд хадгалагдах төлөвтэй болсон тул ХНБ мөнгөний бодлогоо өмнөх төсөөллөөс

²³ Стагфляц нь эдийн засгийн зогсонги байдал болон үнэ, цалингийн өндөр өсөлт нэгэн зэрэг бий болох эдийн засгийн нөхцөл байдал юм.

хурдтай нормалчлахаар байна. Тухайлбал, ХНБ бонд худалдан авалтаа эрчимтэй дуусгаж, бодлогын хүүгээ 2022 онд 4-5 удаа өсгөх хүлээлт үүсээд байна. ОХУ-Украины нөхцөл байдлаас шалтгаалан ОХУ-ын рублийн ханш 2-р сарын сүүлээр огцом суларч, үүний хариу үйлдэл болгон Оросын Төв банк бодлогын хүүгээ 2-р сард 9.5 хувиас 20 хувь хүргэж огцом өсгөлөө.

IV.2 Түүхий эдийн үнэ

Түүхий эдийн үнийн төлөв ОХУ-Украины нөхцөл байдлаас хүчтэй хамаарахаар байна.

Зэс: Зэсийн хамгийн том хэрэглэгч болох БНХАУ-ын аж үйлдвэрийн салбарын борлуулалтын менежерийн индекс сүүлийн саруудад тэлэх чиглэлд өөрчлөгдөв. Нэг тонн зэсийн үнэ 2022 оны 1-р сард дунджаар 9919 ам.доллар байсан бол 2-р сард 9943 ам.доллар болж өсөөд байна. Түүнчлэн, энэ оны 2-р сард металлын биржүүд дээрх зэсийн нөөц түүхэн доод хэмжээ буюу 200.4 мянган тоннд хүрэв²⁴. Зэсийн үнэ дунджаар 2022 онд 9897 ам.доллар/тонн, 2023 онд 9147 ам.доллар/тоннд хүрч өмнөх төсөөллөөс нэмэгдэх хүлээлттэй байна.

Алт: Нийлүүлэлтийн гинжин хэлхээний доголдол үргэлжилж, улс орнуудын инфляц өндөр түвшинд хадгалагдаж алтны эрэлт нэмэгдэв. Нэг унц алтны үнэ 2021 оны 4-р улиралд дунджаар 1796 ам.доллар байсан бол 2022 оны 1, 2-р сард харгалзан 1907 ам.доллар, 1860 ам.долларт хүрсэн байна. Мөн ОХУ-Украины нөхцөл байдал дэлхий даяар тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, алтны үнэ өсөхөд нөлөөллөө. Алтны үнэ 2022 онд 2267 ам.доллар/унц, 2023 онд 1685 ам.доллар/унц-д хүрэх төсөөлөл бий болов.

Коксжих нүүрс: Нэг тонн коксжих нүүрсний үнэ 2021 оны 4-р улиралд дунджаар 322 ам.доллар байсан бол 2022

оны 1, 2-р саруудад харгалзан 408 ам.доллар, 430 ам.доллар болж өслөө. Нүүрсний үнэ өсөхөд эрэлт талаас 1) БНХАУ-ын Австралийн нүүрсний импортод тавих хориг үргэлжилсэн, 2) БНХАУ-ын Засгийн газраас байгаль орчны зорилгоо 2025 оноос 2030 он болгож хойшлуулсан нь коксжих нүүрс, гангийн эрэлтийг нэмэгдүүлсэн 3) ОХУ-Украины хоорондын мөргөлдөөнөөс шалтгаалан байгалийн хийг нүүрсээр орлуулах болсон зэрэг нь нөлөөллөө. Нийлүүлэлт талаас 1) БНХАУ-д “Тэг-КОВИД” бодлого үргэлжилж коксжих нүүрсний импортоо огцом бууруулсан 2) “Бээжингийн олимп 2022”-той холбоотойгоор 2022 он гарсаар БНХАУ-ын нүүрсний үйлдвэрүүд бүрэн хүчин чадлаар ажиллаагүй байна. Цаашид нүүрсний үнийн төлөв БНХАУ-ын Засгийн газраас хэрэгжүүлэх бодлого, дэлхийн эдийн засгийн өсөлт, ОХУ-Украины нөхцөл байдлаас хамаарахаар байна.

Төмрийн хүдэр: Нэг тонн төмрийн хүдрийн үнэ 2021 оны 4 дүгээр улиралд дунджаар 107 ам.доллар байсан бол 2022 оны 1, 2-р саруудад харгалзан 123 ам.доллар, 124 ам.доллар ам.долларт хүрлээ. Хятадын ардын банкнаас барилгын салбарыг дэмжихээр бодлогын төлөвөө сулруулж, 5 жилийн хугацаат бодлогын хүүг бууруулав. БНХАУ-ын Засгийн газраас байгаль орчны зорилгоо 2025 оноос 2030 он болгож хойшлуулснаар цаашид гангийн үйлдвэрүүд үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх, улмаар төмрийн хүдрийн эрэлт өмнөх төсөөллөөс нэмэгдэх төлөвтэй боллоо. Тухайлбал, Блүүмберг, Австралийн Нөөц, Эрчим хүч болон Рубини байгууллагын шинжээчдийн төсөөллийн дунджаар төмрийн хүдрийн үнэ 2022 онд 103 ам.доллар/тоннд 2023 онд 89 ам.доллар /тоннд байх төсөөлөл боловсруулсан байна.

²⁴ <https://www.mining.com/copper-price-global-stocks-are-down-to-three-days-consumption/>

Газрын тос: Нэг баррель Brent маркийн газрын тосны үнэ 2021 оны 4-р улиралд дунджаар \$80 байсан бол 2022 оны 1, 2-р саруудад харгалзан 86 ам.доллар, 94 ам.доллар болж өсөв. Түүнчлэн, ОХУ-Украины нөхцөл байдлаас шалтгаалж 3-р сарын эхэнд газрын тосны үнэ 116 ам.доллар/баррель хүрээд байна. Эрэлт талаас 1) Улс орнуудын эдийн засаг үргэлжлэн сэргэсэн, 2) газрын тосны нөөц бага түвшинд хүрсэн, 3) байгалийн хийн үнэ өсөж газрын тосоор байгалийн хийг орлуулах болсон нь нөлөөллөө. Нийлүүлэлт талаас 1) ОПЕК+ нэгдэл үйлдвэрлэлийн төлөвлөгөөндөө хүрээгүй, 2) Йемений хоутис босогчид Арабын Нэгдсэн Эмират Улс руу удаа дараа дайрсан нь нийлүүлэлтийн тодорхой бус байдлыг үүсгэсэн, 3) Казахстан, Ливийн улс төрийн тогтворгүй байдал, 4) ОХУ-Украины дайны нөхцөл байдал зэргээс шалтгаалж нийлүүлэлтийн тодорхой бус байдал үүсээд байна. Brent маркийн газрын тосны үнэ Рубини, JPMorgan, Economist, Rystad байгууллагын шинжээчдийн төсөөллийн дунджаар 2022 онд 118 ам.доллар/баррель, 2023 онд 96 ам.доллар/баррель болж өмнөх төсөөллөөс нэмэгдлээ. Газрын тосны үнийн цаашдын төлөв ОХУ-Украины нөхцөл байдал хэрхэн өрнөхөөс ихээхэн хамаарахаар байна.

Худалдааны нөхцөл

ҮСХ-ны тооцоогоор манай худалдааны нөхцөл 2021 оны 12-р сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.6 хувиар сайжирав. Нефтийн бүтээгдэхүүний импортын үнэ жилийн 76.5 хувиар өссөнөөс голлон шалтгаалж нийт импортын үнийн индекс 24.9 хувиар нэмэгдсэн байна. Харин нүүрсний хилийн үнэ 252 хувиар өссөнөөс шалтгаалж экспортын үнэ илүү хурдтай буюу 60.7 хувиар нэмэгдсэн нь худалдааны нөхцөл сайжрахад нөлөөлөв. Дэлхийн улс орнуудад инфляц эрчимжсэн, дэлхийн зах

зээл дээрх газрын тосны үнэ, хүнсний үнэ өссөн, тээврийн зардал нэмэгдсэн нь манай улсын импортын үнэ өсөх суурь шалтгаан болов.

Экспортын үнэ өмнөх оноос буурч, худалдааны нөхцөл 2022 онд муудахаар байна (Зураг IV.1.2). Дэлхийн зах зээл дээрх газрын тос, хүнсний үнэ өсөхийн зэрэгцээ улс орнуудын инфляц хурдтай өсөж байгаа нь импортын үнэ өмнөхөөс нэмэгдэхэд нөлөөлж байна. Голлох түүхий эдийн эрэлт нийлүүлэлт тогтворжсоноор экспортын үнэ алгуур буурах хүлээлттэй байна.

Зураг IV.2.1

Худалдааны нөхцөл, экспорт, импортын үнийн өөрчлөлт



IV.3 Төлбөрийн тэнцэл

Урсгал тэнцлийн алдагдал тэлснээр 2021 онд Монгол улсын төлбөрийн тэнцэл 221.6 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Тодруулбал, 2021 оны туршид импорт экспортоос хурдтай тэлж, гадаад худалдааны ашиг буурсан, ААН-үүдийн дахин хөрөнгө оруулалт нэмэгдэж, орлогын дансны алдагдал тэлснээр урсгал тэнцлийн алдагдал өмнөх оноос 2.9 дахин тэлж, ДНБ-ий 13 хувьд хүрсэн байна (Зураг IV.3.2). Урсгал тэнцлийн алдагдлыг ГШХО, гадаад зээлээр голлон санхүүжүүлжээ. Гадаад валютын албан нөөцийн хувьд 2021 оны эцэст 4366.1 сая ам.долларт хүрсэн нь сүүлийн 3 сарын дунджаар тооцсон валютын төлбөртэй барааны импортын 8.0 сарын хэрэгцээг хангах түвшин юм.

Зураг IV.3.1

Төлбөрийн тэнцлийн ашиг буурав.



Зураг IV.3.2

Урсгал дансны алдагдал 2021 онд тэлэв.



Эх сурвалж: Монголбанк

Төлбөрийн тэнцлийн 2021 оны 4 дүгээр улирлын гүйцэтгэлийг авч үзвэл 358.6 сая ам.долларын ашигтай гарсан байна²⁵. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тайлант улиралд урсгал дансны алдагдал тэлж, хөрөнгө, санхүүгийн дансны ашиг буурснаар төлбөрийн тэнцлийн ашиг цэвэр дүнгээр буурчээ (Зураг IV.3.1).

Экспортын орлого тайлант улиралд өмнөх оны мөн үеэс 17.2 хувиар өсөв. Хэдийгээр нүүрсний экспортын биет хэмжээ 60 хувиар бага байсан ч хилийн үнэ өмнөх оны мөн үеэс 4.6 дахин нэмэгдсэн тул нүүрсний экспортын орлого 95 хувиар өсөж, нийт экспорт нэмэгдэхэд хамгийн том нөлөөг үзүүлсэн байна. Харин экспортын бусад томоохон бүрэлдэхүүн хэсгүүдийн хувьд хилийн хязгаарлалтаас шалтгаалж орлого нь өмнөх оны мөн үеэс буурлаа (Хүснэгт IV.3.1). Тухайлбал, КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж БНХАУ-ын хилийн хяналт шалгалт эрчимжиж, улмаар 2021 оны 12-р сард Замын-Үүдийн боомтоор гардаг манай улсын гол түүхий эдүүд болох Эрдэнэт үйлдвэрийн зэсийн баяжмал, төмрийн хүдэр огт гараагүйн зэрэгцээ авто замаар гардаг газрын тосны экспорт саатсан байв.

Хүснэгт IV.3.1

Нүүрсний экспортын орлого нэмэгдсэн нь экспортын өсөлтийг бий болголоо.

сая ам.доллар	2020 IV	2021 IV	Жилийн өсөлт %	Өсөлтөд эзлэх %
Нийт экспорт	2,429	2,848	17.2	17.2
Чулуун нүүрс	648	1,262	94.9	25.3
Зэсийн хүдэр, баяжмал	612	593	-3.1	-0.8
Төмрийн хүдэр, баяжмал	176	104	-40.8	-3.0
Ноолуур	40	89	123.2	2.0
Боловсруулаагүй нефть	65	49	-24.5	-0.7
Цайрын хүдэр, баяжмал	43	34	-22.9	-0.4
Мөнгөжөөгүй алт	622	544	-12.4	-3.2
Мах, махан бүтээгдэхүүн	53	3	-94.8	-2.1
Жонш, лейцит, нефелинг	23	12	-46.1	-0.4
Молибдений хүдэр	11	29	170.5	0.8
Мөнгө	25	28	15.3	0.2
Бусад	113	100	-11.3	-0.5

Эх сурвалж: ГЕГ, Монголбанк

²⁵ Төлбөрийн тэнцлийн дэлгэрэнгүй статистикийг stat.mongolbank.mn хаягт хандан авах боломжтой.

Харин **Оюу толгойн зэсийн баяжмалын** экспорт өмнөх оноос биет хэмжээний хувьд бага хэдий ч тасралтгүй үргэлжилсээр байсан бөгөөд зэсийн үнэ өндөр байсан, тус уурхайн зэсийн баяжмал дахь алтны агууламж жилийн өмнөхөөс 25 хувиар нэмэгдсэн зэрэг нөлөөгөөр экспортын орлого нь 4-р улиралд өмнөх оны мөн үеэс 29 хувиар өслөө.

Импорт 2021 оны 4-р улиралд 26.1 хувиар өсөхөд хөрөнгө оруулалтын бараа бүтээгдэхүүний импортоос бусад бүлэгт том хэмжээний өсөлт бий болсон нь нөлөөлөв (Хүснэгт IV.3.2).

БНХАУ-ын талаас КОВИД-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хязгаарлалтаас шалтгаалж манай улсын импортын барааны тээвэр 10 болон 11-р саруудад хэвийн үеийнхээс удаашралтай байсан бол 12-р сард тээвэр харьцангуй хурдтай орж ирснээр импорт 12-р сард 62.2 хувиар өссөн нь 4-р улирлын импорт ийнхүү өндөр хувиар өсөх шалтгаан боллоо.

Өсөлтөд нөлөөлсөн гол бүрэлдэхүүнийг харвал хүнс, эм тариа, суудлын автомашин, цахилгаан эрчим хүч, химийн бүтээгдэхүүн зэрэг дэд хэсгүүдийн дүн хамгийн ихээр нэмэгджээ.

Хүснэгт IV.3.2

Нийт импорт 4-р улиралд 26.1 хувиар өсөв.

сая ам.доллар	2020 IV	2021 IV	Жилийн өсөлт %	Өсөлтөд эзлэх %
Нийт импорт	1,366	1,722	26.1	26.1
Хэрэглээний бүтээгдэхүүн	433	622	43.7	13.9
Түргэн эдэлгээт	249	374	50.3	9.2
Удаан эдэлгээт	184	248	34.8	4.7
<i>Суудлын автомашин</i>	98	130	33.0	2.4
Хөрөнгө оруулалтын бүт.н	537	518	-3.5	-1.4
Нефтийн бүтээгдэхүүн	234	393	68.4	11.7
Дизель	128	170	32.8	3.1
Бусад шатахуун	106	224	111.6	8.6
Аж үйлдвэрлэлийн орц	151	187	23.3	2.6
Бусад	11	2	-80.3	-0.7

Эх сурвалж: ГЕГ, Монголбанк


Уул уурхайн гол бүтээгдэхүүнүүдийн экспортын тээвэр саатсантай байсантай холбоотойгоор 4-р улиралд нефтийн бүтээгдэхүүний биет хэмжээ 6.5 хувиар бага

байв. Хэдий тийм боловч газрын тосны үнийн өсөлтөөс шалтгаалж нефтийн бүтээгдэхүүний импортын төлбөр өмнөх оны мөн үеэс 68.4 хувиар өслөө.

Үйлчилгээний дансны алдагдал энэ оны 4-р улиралд өмнөх оны мөн үеийн орчимд буюу 396.9 сая ам.доллар байв (Зураг IV.3.3). Тайлант улиралд хилийн нөхцөл байдлаас шалтгаалан тээврийн үнэ өндөрт хадгалагдаж, ачаа тээврийн үйлчилгээний цэвэр орлого нэмэгдэв. Харин гадаад улсад аялах Монгол иргэдийн тоо өсөж, аялалын үйлчилгээний зардал нэмэгдсэний зэрэгцээ томоохон уул уурхайн бүтээн байгуулалттай холбоотой бизнес, худалдааны зардал тэллээ.

Зураг IV.3.3

Үйлчилгээний дансны алдагдал тогтвортой байв.




Эх сурвалж: Монголбанк

Орлогын дансны алдагдал 2021 оны 4-р улиралд 727.5 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 238.2 сая ам.доллаар өссөн нэмэгдэв. Үүнд олон улсын захад түүхий эдийн үнэ өндөр түвшинд хадгалагдсанаар томоохон уул уурхайн компаниудын ашигт ажиллагаа нэмэгдэж, орлогын дахин хөрөнгө оруулалтын цэвэр гарах урсгал өмнөх оноос 285 сая ам.доллаар өссөн нь голлон нөлөөллөө (Зураг IV.3.4).

Зураг IV.3.4

Орлогын дансны алдагдал тэлэв.




Эх сурвалж: Монголбанк

Санхүүгийн дансны тэнцэл 2021 оны 4-р улиралд 438.2 сая ам.долларын ашигтай байсан нь өмнөх оны мөн үеэс 535.4 сая ам.доллароор бага буюу 55 хувиар буурсан үзүүлэлт болов. Үүнд гадаадын шууд хөрөнгө оруулалт 140 сая ам.доллар, багцын хөрөнгө оруулалт 75 сая ам.долларын эерэг нөлөө үзүүлсэн хэдий ч бусад хөрөнгө оруулалт 751 сая ам.доллароор буурсан нь голлох нөлөөг үзүүллээ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт тайлант улиралд 597.6 сая ам.доллар болж өмнөх оны мөн үеэс 30.5 хувиар өсөв. Үүнд Оюу толгойн хөрөнгө оруулалт орж ирээгүй ч бусад аж ахуй нэгжүүдийн хөрөнгө оруулалт нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

Зураг IV.3.5

Санхүүгийн дансны ашиг өмнөх оны мөн үеэс буурав.



Эх сурвалж: Монголбанк

Тайлант улиралд бусад хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 751 сая ам.доллароор буурч 185.4 сая ам.долларын гарах урсгалтай байв. Энэхүү өөрчлөлтөд томоохон экспортлогч аж ахуй нэгжүүд өмнөх улирлуудын авсан урьдчилгаага эргүүлэн төлж, худалдааны зээл 500 сая ам.доллароор буурч 201.4 сая ам.долларын гарах урсгалтай байсан голлон нөлөөлөв. Мөн банкууд дахь оршин суугч бусын хадгаламж буурснаар бэлэн мөнгө, харилцах данс өмнөх оноос 137.4 сая ам.доллароор буурч 135.9 сая ам.долларын гарах урсгалтай байв. Нөгөөтэйгүүр алтны санхүүжилтийн зорилгоор 200 сая ам.долларын гадаад зээлийг авсан, бусад бизнесийн томоохон аж ахуй нэгжүүд гадаад зээлийг авсан нь санхүүгийн дансны орох урсгалыг мөн нэмэгдүүллээ.

Хүснэгт IV.3.3

Төлбөрийн тэнцлийн төсөөлөл гаргахад ашигласан таамаглал 2022 он

Төлбөрийн тэнцлийн төсөөлөлд оруулсан өөрчлөлт (2022)

Экспорт	Өмнөх төсөөлөөс буурсан
Биет хэмжээний төсөөлөл: Нүүрс -9 сая тонн ↓, зэс ↓, төмрийн хүдэр ↓, газрын тос ↓, мах ↓ Үнийн төсөөлөл: Зэс ↑, нүүрс ↑, газрын тос ↑, алт ~, төмрийн хүдэр ↓	
Импорт	Өмнөх төсөөлөөс нэмэгдсэн
Эдийн засгийн идэвхжил, импортын үнэ ↑ → Хэрэглээний импортын төлбөр ↑, Газрын тосны үнэ ↑, нүүрсний экспорт ↓ → цэвэр дүнгээр нефтийн бүтээгдэхүүний импорт ↑, Криптовалютыг импортлох бүртгэх болсон.	
Үйлчилгээ	Өмнөх төсөөлөөс сайжирсан
Нүүрсний экспорт ↓, импорт ↑ → тээврийн цэвэр урсгал ↑. Аялал, жуулчлал алгуур сэргэж, аялалын орлого, зардал алгуур тэлнэ. Бусад үйлчилгээний зардал өмнөх төсөөллийн орчимд	
ГШХО	Өмнөх төсөөллийн орчимд
Өөрчлөлтгүй. ОТ-н гүний уурхайн бүтээн байгуулалт үргэлжилнэ.	
Багцын ХО	Өмнөх төсөөллийн орчимд
Төсөөлөл өөрчлөлтгүй. МУЗГ Чингис бондын үлдэгдэл төлбөрийг эргэн төлнө. МИК Өэлүн бондын үлдэгдэл төлбөрийг 1-р сард төлөв.	
Бусад ХО	Өмнөх төсөөлөөс сайжирсан
Засгийн газрын гадаад зээлийн ашиглалт ↑, хувийн секторын зээлийн эргэн төлөлт ↓, Төв банкны зээлийн эргэн төлөлт ↑. Криптовалютыг Импортын дансанд бүртгэснээр бэлэн, мөнгө, харилцахын гарах урсгал буурав.	

Эх сурвалж: Монголбанк



МОНГОЛБАНК